


ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ГААЛИЙН ТОГТОЛЦОО

4.1 Гаалийн байгууллагын үйл ажиллагаа (1) Татварын орлого

Монгол улсын эдийн засагт гаалийн байгууллага ихээхэн ач холбогдолтой. Гааль нь экспорт импортын бараанд гаалийн татвар, НӨАТ болон онцгой албан татвар ногдуулдаг ба 2001 оны улсын татварын орлогод эзлэх гаалийн татварын орлого 40 хувиас илүү байна.



Зураг 4-1. Улсын татварын орлого дахь гаалийн орлогын үзүүлэлт
(Монголын гаалийн байгууллагын материалаас)

Гаалийн байгууллагын материалаас үзвэл, 1999 оны улсын татварын орлогод эзлэх гаалийн орлого 37% гэж байгаа ба үүнийг Санхүү эдийн засгийн яамны материалтай харьцуулан үзэхэд ч ижил үр дүнтэй байна. Энэ нь гааль улсын төсөвт хэчнээн чухал үүрэгтэйг үзүүлэхийн зэрэгцээ бусад татвар бүрдүүлэх механизм нь хэчнээн сул болохыг харуулж байна.

Хүснэгт 4-2. Гаалийн орлогын дэлгэрэнгүй, нийт татвартай харьцуулсан нь


(Санхүү эдийн засгийн яамны материалаас)

	Мөнгөн дүн	Эзлэх хувь
Улсын татварын орлого	182,510.6	
НӨАТ (импортын)	31,768.4	17
Онцгой албан татвар (!)	26,667.0	15
Гаалийн татвар	5,849.6	3
Экспортын татвар	3,161.4	2
Нийт гаалийн орлого		37

(!) онцгой албан татварын нийт дүн (бүгдийг гааль бүрдүүлсэн гэж үзвэл, гаалийн орлого нийт татварын орлогын 37хувийг эзлэнэ. Хэрэв хагасыг гэвэл 29% болно.

Хүснэгт 4-2.-оос үзвэл НӨАТ-ын орлогыг (татварын хувь 15) гаалийн татварын орлоготой (татварын хувь 7) харьцуулахад, гаалийн татварын эзлэх хувь хэтэрхий бага (татварын хувиар бол гаалийн татвар НӨАТ-ын 1/3 орчим байх ёстой) гэж үзэж болно. Энэ нь татваргүйгээр болон татвараас чөлөөлөгдөн импортлох тохиолдол их байдгийг илтгэнэ.

Өөрөөр хэлбэл, тусламжийн эд бараа болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн түүхий эд зэрэг ихэнх хувийг эзэлж, ердийн гаалийн татвар ногдуулах бараа бага байдаг гэсэн үг. Үнэхээр ч, нисэхийн гаальд мэдүүлсэн импортын барааны үнийн дүнгийн 36 хувь нь л татвар ногдуулах бараа байна. Мөн төслийн монгол хамтран ажиллагчийн хэлснээр бол, нийт импортын үнийн дүнгийн 40% нь татвараас чөлөөлөгдөх болон татваргүй бараа байдаг учир гаалийн татвар ногдуулах бараа бага байдаг аж.



Зураг 4-3. Нисэхийн гаалийн хилээр нэвтэрсэн импортын бүтэц (2001 он)

(Нисэхийн гаалийн материалаас)

Гаалийн татварын бүтэц нь, гаалийн татвар ч , НӨАТ ч тэгшитгэсэн хувьтай учраас татвар бодоходоо, мэдүүлгийн үнийн дүнг тодорхой хувиар үржүүлэхэд л болох маш хялбар системтэй юм.

- Импортын гаалийн албан татвар (2002.1.1-ээс 5% болж буурсан)
Импортын гаалийн албан татварыг газар тариалангийн бүтээгдэхүүн зэргээс бусад бүх төрлийн импортын бараанд ижил 5 хувиар ногдуулна. Өөрөөр хэлбэл, ямар ч төрлийн бараа байсан ижил хувиар татвар ногдуулдаг хялбар системтэй болохоор гаалийн татварын тооцоо хийхэд тийм их цаг хугацаа зарцуулагдах ёсгүй.
Даяарчлалын өнөө үед гаалийн татварыг багасгах, бууруулах чиг хандлагатай байгаа нь мэдээжийн зүйл. Улсын татварыг бүрдүүлэх үүднээс гаалийн татварын хувийг нэмэгдүүлэх нь энэхүү чиг хандлагад харшлах болно.
Мөн технологи болон түүхий эдийн импортонд голлон тулгуурладаг Монголын хувьд гадаадын хөрөнгө оруулалтыг татах, үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн тулд тоног төхөөрөмж зэргийн импортонд хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээ авахаас өөр аргагүй байдаг тал бий.
- НӨАТ
НӨАТ-ыг 15 хувиар ногдуулдаг. НӨАТ-ын орлогын 54 хувийг гааль бүрдүүлсэн байгаа ба дотоодын бүрдүүлэлтээс ч их хувь гаальд ногдож байна. Энэ нь дотоодын НӨАТ-ын бүрдүүлэлт тун хангалтгүй байгааг гэрчлэнэ.
- Онцгой албан татвар
Онцгой албан татварыг архи спиртийн төрлийн ундаа, автомашин, тамхи зэрэгт өндөр тарифаар ногдуулна. Энэхүү татварыг төлснөөр, тухайн барааны үнэ мөн өндөр болдог учраас эдгээр барааг хууль бусаар хил нэвтрүүлэх нь их байдаг аж. Архи, тамхи зэрэг зайлшгүй хэрэгцээт бус бараа элбэг. Эдүгээ зохих ёсоор татвар төлөгдсөн бараанд татварын тэмдэг тавьж, татвар төлснийг илтгэх тогтолцоо бүрдүүлж байгаа бөгөөд тэмдгийг

хуурамчаар үйлдсэн тохиолдол гарсан байна. Уг нь гаалийн хяналт шалгалтан дор татвар төлсөн бараанд гэрчилгээ олгодог тогтолцоо бий болгон, хууль бусаар импортлосон эсэхийг дотоодын зах зээл дээр хялбархан хянаж чадах бүтэц зохион байгуулалт хэрэгтэй. Татварын байгууллагын хувьд ч, энэ системээр татвар төлөгчдийн бизнесийн үйл ажиллагааг тодруулж чадвал тухайн барааг импортлох үед хууль бус үйл ажиллагаа болсон эсэхийг мэдэх боломжтой гэж үзэж болно. Гэвч тэмдэг наах тогтолцоо нэвтрүүлэхэд зардал нэмэгдэх асуудал ч бий. Онцгой албан татвар нь нэг төрлийн гүйлгээний татвар учраас аль болохоор НӨАТ-т шингээх арга олон улсын туршлагад бий.

- **Экспортын албан татвар**

Экспортын албан татварыг арьс шир, хаягдал төмөрлөгийн зүйлд ногдуулна. Ер нь орлогын том эх үүсвэр болдоггүй.

Олон улсын стандартаар бол, олон улсын чөлөөт өрсөлдөөнд саад тотгор учруулдаг гэсэн үндэслэлээр экспортын татварыг хэрэглэхгүй байх хандлагатай байгаа билээ. Монголын экспортын барааны голлох зүйл нь нэхмэл болон эрдэс бүтээгдэхүүн бөгөөд нэхмэлд нь ноос ноолуур орно. Экспортын татварт боловсруулаагүй ноолуурыг Хятад улс руу гаргахаас сэргийлэх тал байдаг ч, ноолуурыг монголын дотоодын үйлдвэрлэгчдээс, хятадын худалдаачид нь илүү өндөр үнээр худалдан авдаг нь үнэн юм. Ийм байдлаар экспортын татвар нь зүй зохист бизнесийн үйл ажиллагаанд саад болох тал ч бий. Эрдэс бүтээгдэхүүн нь зөвхөн хаягдал төмөрлөгийн зүйл бөгөөд голлох бүтээгдэхүүн болох үнэт металл нь татваргүй байна. Олон улсын хэмжээнд экспортын татваргүй болох чиг хандлага байгаа учир үүнтэй уялдаад Монгол улс ч экспортын татварын хувийг нэмэгдүүлэх гэвэл хүндрэлтэй байх болно.


Өнгөрсөн 10 жилд гаалийн байгууллагын үүрэг, улсын татварын системд эзлэх хувь эрс өссөн байна. Ингэж гаалийн байгууллагын татвар бүрдүүлэх үүргийг чухалчлан үзснээс болоод, гаалийн нөгөө нэг үүрэг болох “түргэн шуурхай үйлчлэхэд” нь саад учирч буй гэж үзэж болохоор байна.

(2) Гадаад худалдааны түнш орнууд

Монгол улсын худалдааны түнш орон нь зураг 4-4-т үзүүлсний дагуу болно. ОХУ, БНХАУ, Япон, БНСУ гол түнш орон болно. Үүнээс хамгийн гол түнш нь ОХУ бөгөөд эзлэх хувь өсч буй. Энэ нь нефтийн бүтээгдэхүүний эзлэх хувь их учраас юм. ОХУ-аас импортлодог барааны 50 орчим хувийг нефтийн бүтээгдэхүүн эзэлдэг. Мөн Япон улсын эзлэх байр суурь харьцангуй буурсан бол Хятад улсын эзлэх хувь эрс өссөн байна.

Гадаад худалдааны статистик мэдээлэлд «бусад» гэсэн ангилалд хамрагдах өргөн хэрэглээний бараа 1999 оноос 2001 оны хооронд 70 орчим хувиар өссөн байна. Өргөн хэрэглээний бараа нь гаалийн татвар хураах гол зүйл бөгөөд 2001 онд БНХАУ-аас импортлосон өргөн хэрэглээний бараа ОХУ-ынхаас илүү гарч байна. БНХАУ нь дунд болон урт хугацаанд амжилттай хөгжинө гэдэг нь тодорхой харагдаж байгаа бөгөөд Монгол улсын хувьд импортын түнш Хятад улсын ач холбогдол маш их гэж үзэж болно.

Зураг 4-4. Импортлогч орнуудын гадаад худалдаанд эзлэх хувь, өөрчлөлт



Гадна: 2001 он Дунд: 2000 он Дотор: 1999 он

Хөрш хоёр улсаас импортлодог гол нэрийн бараа (сая ам.доллар)


ОХУ	1999 он	2000 он	2001 он
Нефтийн бүтээгдэхүүн	65.7	100.8	111.9
Хөнгөн тэрэг	6.2	12.9	5.8
Гурил	3.8	7	6
Бусад	74.1	86.1	78.2
Нийт	149.8	206.2	201.9

БНХАУ	1999 он	2000 он	2001 он
Нефтийн бүтээгдэхүүн	3.3	6.1	5.4
Гурил	2.1	8.9	8.6
Хөвөн даавуу	8.5	9.6	6
Бүх төрлийн ноосон ээрмэл	9.2	11.5	7.9
Бусад	45.9	73.4	79.4

(3) Гаалийн үйл ажиллагааны бодит байдал

Энд гол үндсэн бааз болох төмөр замын Улаанбаатар өртөөг жишээ болгон Монгол улсын импортын барааны гаалийн хилээр нэвтрэх системийн тухай судлан үзэв.

(1) Импортын урсгал



Зураг 4-5. Гаалийн хилээр нэвтрэх импортын барааны урсгал

(Монголын төмөр замын хувьд)

Монголын гааль нь импортын үйл ажиллагаандаа

- гаалийн зуучлагчийн систем нэвтрүүлэх
- зуучлагчийн үйл ажиллагааны тухай хуулийг авч хэрэглэх
- гаалийн баталгаат системийн зүй зохист ашиглалт

зэрэг хууль зүйн хувьд бол Японтой ижил системийг бүрдүүлэн хэрэгжүүлэхээр чармайж буй бөгөөд ерөнхий чиг хандлагын хувьд олон улсын стандартаас зөрөх асуудал үгүй.

Ачаа барааны гаалийн хилээр нэвтрэх урсгал дараахь байдалтай болно.

① Гаалийн нутаг дэвсгэрт (өртөөнд ирэх) оруулах

Хил нэвтрэн орж ирсэн олон улсын барааг гаалийн харъяаны нутаг дэвсгэрт оруулна. Буух өртөөндөө хүрсэн нь тодорхой болсон ачаа барааны хувьд мэдүүлэг бичих боломжтой болно.

- Үйл ажиллагааны бодит байдал

- Улаанбаатар хотод нийт 8 терминал байх (төмөр замын шугамын дагуу) бөгөөд тэнд нь гаалийн баталгаат бүс (гаалийн баталгаат агуулах) байдаг.
- Гаалийн баталгаат агуулах, бүсийг эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгох ба нөхцөл болзлийн талаар Гаалийн хуулинд тусгасан буй.

② Гаалийн зуучлагч

Гаалийн зуучлагч байж, тэнд мэдүүлэг бичих нь үндсэн зарчим. Импортлогчид гаалийн зуучлагчаас :

а .зөвхөн гаалийн мэдүүлэг бичих

б .мэдүүлэг бичих, гаалийн татварын тооцоо хийх, ачаа барааг үзлэг шалгалтанд оруулах, хүлээн авах хүртэлх бүх ажлыг хариуцах гэсэн 2 хэлбэрийн үйлчилгээ үзүүлдэг.

Гаалийн зуучлагчийн ажлын тогтсон тариф гэж байхгүй ч ойролцоогоор а. 4 ам.доллар, б. 20~30 ам.доллар байдаг бололтой. Хувь хүний хувьд а.хэлбэрээр үйлчлүүлэх нь их. б. хэлбэрийг, зээл тусламж, төсөл, том аж ахуйн нэгж буюу гаальд үнэн зөв мэдүүлдэг газар л ашиглахаас хэтрэхгүй.

а.-ийн хувьд, импортлогч уг хүн өөрөө гаалийнхантай шууд харьцаж, алдаж онон, зөвшөөрөл авах хүртэл явдаг ба бүтэлгүй болсон тохиолдолд тухайлбал, «мөнгөөр асуудлыг шийдвэрлэх» гэсэн явдал гаран, хээл хахуулийн үндэс болох боломжтойг үгүйсгэх аргагүй.

Уг нь б. хэлбэрийг нэмэгдүүлэх хэрэгтэй ч, импортлогчийн хувьд даруй 10 дахин их зардлыг дуртайяа хүлээн авч чадах эсэх нь эргэлзээтэй.

-Үйл ажиллагааны бодит байдал

- Гаалийн газарт гаалийн зуучлагч байрлаж, тэндээ мэдүүлэг бичин, гаалийн хүлээн авах газарт мэдүүлнэ.
- Гаалийн зуучлагч гаальд мэдүүлэхээс (бичиг баримт) өмнө ачаа бараа ирсэн гаалийн газарт хандан, ачаа бараа үнэхээр ирсэн эсэхийг нягталж, гаалийн мэдүүлэгт тэмдэг тавиулна. Үүнийг энэ удаагийн компьютерийн системээр автоматжуулахаар төлөвлөөгүй.

③ Гаальд мэдүүлэх

Гааль нь хүлээн авсан материалд үндэслэн, мэдээллийг компьютерт шивж оруулан (гаалийн категорит оруулан өөрчлөнө), мэдүүлгийн үнэн зөв эсэхийг шалгана. Энэ бичилт нь үнийн нэхэмжлэх дэх мэдээллийг тэр хэвээр нь дахин бичиж буйтай адил учир цаг хугацааны хувьд ч, хүн хүчний хувьд ч зардал чирэгдэл ихтэй. Үүнийг шийдвэрлэхээр шинэ систем нэвтрүүлэхээр зорьж байгаа юм. (гаалийн зуучлагчийн бичсэн мэдээллийг тэр хэвээр нь ашиглах). Гаальд мэдүүлэхээс зөвшөөрөл өгөх хүртэлх гаалийн хилээр нэвтрэх программаас гадна, түүндээ үндэслэн статистик мэдээллийн (гадаад худалдаа эрхлэгч, бараа, хэмжээ, үнэ зэрэг мэдээнээс гаалийн татвар төлөлтийн мэдээ хүртэл хадгалагдах) программ нэвтрүүлэхээр зорьж буй бөгөөд мэдүүлэг/зөвшөөрөл системийг эн тэргүүнд авч хэрэгжүүлнэ.

-Үйл ажиллагааны бодит байдал

- Гаалийн мэдүүлэг хүлээн авах цонхон дээр явагдах ба гаалийн ажилтан бичиг баримтан дээрх мэдээллийг гаалийн албаны компьютерт оруулан хянаж шалгана. Ачаа барааны үзлэг шалгалт нь гаалийн баталгаат агуулах дахь ачаа барааны үлдэгдэл хэмжээ, мэдүүлсэн үнийн дүнг нягтлах гэсэн аргачлалаар явагдана. Гаалийн мэдүүлэг хүлээн авах цонх нь ① онцгой албан татвар, ② дотоодын ААНБ, ③ гадаадын хөрөнгө оруулалттай ААНБ, олон улсын байгууллага, ④ тусгай зориулалттай зүйл гэсэн ангилалтай байх ба үйлчлүүлэгчид тус бүрийнх нь өмнө гааль мэдүүлгийг нь компьютерт оруулахыг хүлээн зогсоно.
- Үүний дараа тухайн оруулсан мэдээ үнэн зөв эсэхийг хянадаг алба хянана. Мэдүүлж буй зүйл олон байх тохиолдолд талыг нь шивэн, хянуулаад цааш шивнэ.
- Ижил төрлийн барааг нэгтгэн, нийт үнийн дүнг мэдүүлэгт тусгахгүй, нэгж үнэ л өөр бол

түүнийг тусад нь шивж оруулна (барааны үнийн нэхэмжлэлийг тэр чигээр нь хуулбарлаж буйтай адил). Тийм учраас цаг зав, мэдүүлгийн хөлс ч шаардагдана (ихэнх улсад ижил төрлийн барааг нэгтгэн мэдүүлдэг).

④ Бичиг баримтын шалгалт

Гаалийн татвар тэгшитгэсэн хувьтай учраас гаалийн татварын үндэс болох мэдүүлгийн үнийн дүнг (нэгж үнэ х тоо ширхэг) хүлээн зөвшөөрөх эсэх нь асуулт болно. Өөрөөр хэлбэл, гааль

- Татвар төлөгчийн мэдүүлгийг үндсэнд нь хүлээн зөвшөөрөх үү
 - Гааль мэдүүлгийн үнийг өөрсдийн жишиг үнээр тогтоох уу
- гэдгийн алийг нь сонгосноос болоод зарцуулагдах цаг хугацаа их ялгаатай болно. Үнэ тогтоох арга нь гаалийн хуулинд ч тусгагдан

- Борлуулалтын үнэ
 - Ижил төрлийн бүтээгдэхүүний үнэ
 - Дотоодын бүтээгдэхүүний үнэ
- гэсэн дарааллаар авч үздэг байна. Энэхүү мэдүүлгийн үнийг Олон улсын худалдааны байгууллагын (WTO) журамтай адил байдлаар тогтоодог.

Гэхдээ бодит байдалд, үнийн нэхэмжлэхэд бичигдсэн худалдан авсан үнэ нь тохиролцож өөрчилсөн үнэ байдаг гэдгийг гааль, гаалийн зуучлагч, экспорт, импортлогч аль аль нь хүлээн зөвшөөрдөг.

Үүний шалтгаан нь, үйлчлүүлэгчийн мэдүүлэгт аль болох итгэх гэсэн ойлголт бага байдаг оршино. (мөн татварын орлогыг нэмэгдүүлэх үүднээс нарийн чанд шалгах шаардлагатай байдаг)

-Үйл ажиллагааны бодит байдал

Гааль өөрийн тогтоосон үнийн дагуу бараа тус бүрийн мэдүүлэг дэх үнийн дүнг шалгана. Компьютерийн систем нэвтрүүлэхээс өмнө бол ном хэлбэртэй мэдээллийн хуудсыг эргүүлэнгээ хянаж байв. Харин систем нэвтэрснээр тухайн мэдээллийн бааз нь компьютерийн мэдээллийн санд орон, хяналтын цаг багасна.

⑤ Гаалийн татвар төлөлт

④ -т тогтоосон гаалийн татварыг төлнө. Гаалийн байгууллага дотор байх банкаар дамжуулан шилжүүлэг хийж болох боловч хувь хүн бол ихэвчлэн бэлэн мөнгөөр төлдөг.

⑥ Ачаа барааны үзлэг шалгалт

Ачаа барааг зайлшгүй шалгадаг нь Монголын гаалийн онцлог юм. Ачаа барааны тоо хэмжээ, төрөл зүйлийг нэг бүрчлэн нарийвчлан шалгадаг бөгөөд мэдүүлгэн дээр бичсэн болон бодитоор байгаа бараа яв цав таарч байгаа эсэхийг магадлана. Үүнд багагүй цаг хугацаа орохын зэрэгцээ энэ нь импортлогчтой ямар нэгэн байдлаар далд тохиролцох зэрэг хууль бус үйлдлийн үндэс суурь болох магадлал ихтэй.

Гэвч нисэхийн гаалийн хувьд ачаа барааны шалгалтаас чөлөөлөх (найдвартай татвар төлөгчийн тухайд аравт нэг удаа хүртэл шалгалтын тоог цөөрүүлэх) бодлого баримталдаг бөгөөд цаашид улам өргөжүүлэх нь зүйтэй. Одоогоор ингэж хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлдэг компани 3 л байдаг ба гаалийн үзлэг шалгалтын улмаас цаг хугацаа алдах болон тодорхой бус байдал зэрэг нь гадаадын хөрөнгө оруулагч болон гадаад худалдааны эргэлт ихтэй ААНБ-ын хувьд маш их хүндрэлтэй байдаг ба өөрчилж сайжруулах талаар санал хүсэлт олонтаа гардаг ажээ.

-Үйл ажиллагааны бодит байдал

- Гаалийн баталгаат агуулах нь барилга дотор байдаг ч задгай талбайд ажиллах явдал ч их байна.
- Бүх баглаа боодлыг шалгах нь шалгалтын үндэс болно (чингэлэг дэх хайрцагны тоо ширхгийг нэг бүрчлэн шалгана).
- Гааль хайрцгийг нээж үзэх эрхтэй ч, нээж үзсэн хайрцагтаа тэмдэг тавидаггүй (энэ нь олон улсын стандартад үл нийцнэ). Гааль барааг нээж үзсэн баримт үлдээх нь дэмий хардлагаас зайлсхийх нэг арга болох юм.

(2) Нисэхийн гааль

Нисэхийн гааль нь төмөр замын гаалиас дараахь ялгаатай.

○ Нисэхийн гааль

- Ачаа барааны хэмжээ бага
 - Гаалийн татварын орлогын 6 хувийг эзэлнэ.
 - Нислэгийн тоо цөөн. Эдүгээ олон улсын нислэг өвлийн улиралд өдөрт 3 удаа, зуны улиралд 7 удаа. Нислэгийн зам Бээжин, Сөүл, Москва, Иркутск, Берлин, Японоор хязгаарлагдана. Ачаа тээвэрлэлтэнд ачааны бус зорчигчийн онгоц ашигладаг.
 - Худалдааны ачаа бараа тээвэрлэлтээр байнга үйлчиллүүлдэг нь Мобиком, Скайтел (компьютер, гар утас), ТБТ(өнгөт метал) гэсэн 3 компани. Эдгээр дотроос эхний 2 компани 80 хувийг эзэлдэг байна (бусад нь тусламжийн болон элчин сайдын яам зэргийн ачаа).
 - Агаарын тээврээр экспортлодог ачаа бараанд ноолууран болон тарваганы арьсан бүтээгдэхүүн орно. Үүний 70 хувийг Япон руу экспортлодог.
 - Импортын үнийн дүнгийн 40 хувийг Япон эзэлнэ. Агаарын тээврийн хөлсийг төлж чадах үйлчлүүлэгчийн хувь бага, мөнгөн дүнгээс үзвэл тусламжийн ачаа бараа зонхилно.
- Үйлчилгээ нь хөнгөн шуурхай
 - Ачааг онгоцноос буулган терминалд оруулах ажлыг МИАТ гүйцэтгэнэ. 2 цагийн дотор оруулах журамтай ч, эдүгээ 1 цагийн дотор гүйцэтгэдэг.
 - Агаарын тээвэрлэлт нь найдвартай үйлчлүүлэгчийн ачаа барааг үзлэг шалгалтаас (сард нэг удаа л шалгана) чөлөөлөх үйлчилгээ үзүүлдэг байна.

Монголын агаарын ачаа тээвэрлэлт нь ачаа тээвэрлэх хөлсийг төлж чадах үйлчлүүлэгч цөөн учир өнөөгийн цомхон барилга байгууламж нь ч (Ачаа барааны терминалийн хэмжээ 15m X 15m) хангалттай хүрэлцэнэ. Үүнтэй уялдаад гаалийн ажил ч төвөг чирэгдэл багатай. Төмөр замын гааль дээр авч хэрэгжүүлдэггүй ачаа барааны үзлэг шалгалтын уян хатан бодлого нь (угаасаа импортлогч цөөн гэдгийг үгүйсгэхгүй ч) Монголын гаалийн дэвшилтэт хандлагын бодит жишээ болон анхаарал татна.

Цаашид ачаа барааны хэмжээ нэмэгдэнэ гэвэл одоогийн техник тоноглолоор үйлчилгээний байдал нь хадгалагдаж чадах эсэхийг судалж үзэх шаардлагатай.

(3) Гаалийг хэрэглэгчийн зүгээс харах нь

Хэрэглэгчийн зүгээс гаалийн байгууллагад өгөх үнэлэлт дүгнэлт дараахь байдалтай байна.

○ Гаалийн зуучлагчдыг төлөөлөх санал хүсэлт

- Гаалийн зуучлагч ① мэдүүлэг бичих ② мэдүүлэг ~ гаалийн татвар ~ ачаа барааны үзлэг шалгалт ~ ачаа барааг татаж авах гэсэн ажил гүйцэтгэнэ. Дээрх 2 хэлбэрээр захиалга хүлээн авах нь нийтлэг. Ажлын хөлсний тогтсон тариф үгүй, тухайн компанийн хувьд ①-ийг 4 ам. доллар, ②-ыг 20 ~ 30 ам.долларын хөлсөөр хийж гүйцэтгэнэ. Хувь хүний хувьд ①-ээр үйлчлүүлэх нь их. ②-оор тусламжийн болон төслийн ачаа бараа, том ААНБ л үйлчлүүлдэг нь бодит байдал юм. ②-ын тухайд үнэн зөвөөр мэдүүлэхээс зайлсхийдэггүй үйлчлүүлэгч захиалга өгөн, гаалийн хилээр нэвтрүүлэх ажилд мэргэшсэн гаалийг зуучлагч гаальтай харьцдаг бол ①-ийн хувьд импортлогч өөрөө холбогдох байгууллагатай харьцаж, өөрийн хүчээр явах тул ямар нэгэн хүндрэл бэрхшээл гарсан тохиолдолд хуулийн дагуу ажилллах бус харин мөнгөөр асуудлыг шийдэхээс өөр аргагүй болдог байна. Үйлчлэгч компанийн хувьд ②-ийг сонгох нь зүйтэй гэж үзэж буй ч хэрэглэгчийн хувьд бол хөлс нь их гэж үздэг болов уу.

- Ачаа барааны үзлэг шалгалтыг уян хатан болгох санал хүсэлт гардаг нь тодорхой. Гэвч үзлэг шалгалтаар барааны нэр төрлийг өөрчилсөн, тоо хэмжээг дарсан зөрчлийг илрүүлэх тохиолдолд, зүй нь залруулж мэдүүлэх ёстой ч гааль хурааж авах, эсвэл гаалийн байцаагчид хэдийг ч юм өгөн зөвшөөрөл авах нь ч олонтаа гардаг аж.
- Гааль 3 сар орчим хугацаанд өөрийн жишиг үнийг өөрчилдөг. Энэ нь ханшний өөрчлөлтийг бодолцож үзээгүй байдаг тул 3 сарын дараахь үнийн нэхэмжлэх дээрх үнэ гаалийн жишиг үнэтэй ихээхэн зөрдөг гэсэн импортлогчдын гомдол их гардаг байна.
- Импортлогчдын гадаад худалдааны талаарх мэдлэг дутагдах асуудал ч байна. Тийм учраас ажил үүргийн хувьд найдвартай мэдүүлэгч ховор гэж ойлгогдоно.
- Гаалийн шалгалт өдрөөр хязгаарлагдах тул 16 цаг өнгөрвөл дараагийн өдөрт шилжинэ.

○ Импортлогчдыг төлөөлөх санал хүсэлт

- Ачаа барааг бүгдийг гарган шалгаж, буцааж ачих нь өртөг, зардлын хувьд үр ашиггүй гэдэг нь ойлгомжтой. Иймэрхүү юманд зардал гаргаж байснаас өөр зүйлд хүчээ зориулах нь илүү үр ашигтай байх болно (Сингапурт ачаа бараа шалгахгүй байхад нь маш их гайхсан).
- Засгийн газар ард түмэндээ итгэхгүй, юуны түрүүнд сэжиглэх гэсэн философи арилаагүй байхад тогтолцоо, системийг хэчнээн өөрчлөн бүрдүүлсэн ч үр дүн бага байх болно.
- Хуулийг чанд баримтлан ажилладаг компанийн хувьд үйл ажиллагаанд нь томоохон саад хязгаарлалт учирдаг нь гашуун болов ч үнэн бодит байдал.
- Гаалийн хилээр ачаа бараагаа нэвтрүүлэхийн хувьд тусгайлан нэг ажилтандаа гаалийг хариуцуулсан (Гаалийн зуучлуулагчаар зөвхөн мэдүүлэг бичүүлдэг гэсэн үг). Тэр хариуцсан ажилтан нь гаальтай харьцан, тухайн тухайн нөхцөлд нь тааруулан (үнэн зөв процедураас ангид аргыг ч хэрэглэн) гаалийн хилээр нэвтрүүлэх ажлаа гүйцэтгэдэг нь үнэн.
- Өнөөгийн энэ мэдээллийн технологийн (IT) эринд «цаасанд» тулгуурласан системийг өөрчлөн сайжруулах ёстой болов уу. Компьютерээр мэдээлэл боловсруулах нь мэдээжийн хэрэг байх ёстой зүйл бөгөөд төрийн захиргааны байгууллагын түргэн шуурхай үйлчилгээг хүсч байна.

4.2 Хилийн гаалийн байдал

БНХАУ, ОХУ-аас орж ирэх ачаа барааны урсгал нь олон улсын ачаа эргэлтийн гол үүд болно. Гаалийн хилээр нэвтрүүлэх ажлын гүйцэтгэлээс харсан ч гол 3 цэг (БНХАУ-тай хиллэх Замын-Үүд, ОХУ-тай хиллэх Сүхбаатар, нийслэл Улаанбаатар) дээр мэдүүлгийн үнийн дүнгийн 95 хувь, мэдүүлгийн тооны 85 хувь нь хийгдсэн байна. Монгол улсын олон улсын ачаа эргэлт Хятад → Замын-Үүд → Улаанбаатар, Орос → Алтанбулаг → Улаанбаатар гэсэн гол 2 урсгалтай.

Гэхдээ Монгол улс нь эргэн тойрон өөр улсуудаар хүрээлэгдсэн эх газрын улс учир ямар ч газраар хил нэвтрэх боломжтой. Тийм учраас гааль улирлын чанартай шороон замаар тээвэр хийн, хил нэвтрэх боомт (хилийн түр боомт) ажиллуулдаг. Гэтэл эх газрын улс гэдэг энэ онцлогоос болоод албан ёсны гаалийн боомт бус газраар хууль бус экспорт, импорт хийх боломж их байдгийг үгүйсгэх аргагүй. Тийм ч учраас зам харилцааны гол гол цэгт улирлын чанартай түр зуур нээгддэг боомт ажиллуулан, гаалийн үйлчилгээ үзүүлдэг ч улсын нийт хилийн шугамыг 24 цагийн турш хамгаална гэдэг боломжгүй биз ээ. Монголын гаалийн хуулинд «Гааль нь «гаалийн заасан гарцаар» ачаа барааг нэвтрүүлж, тэрхүү ачаа барааны гаалийн бүрдүүлэлтийг хийнэ» гэж заасан байдаг учир «гаалийн

заасан гарцаас» гадуурх хууль бус хил нэвтрэлтийг гааль хянаж хариуцах эрх үүрэг байхгүй юм. Энэ үүргийг Хилийн цэргийн газар хүлээнэ. Тэд:

- Өөрсдийн хариуцсан хэсэгт эргүүл хийн,
- Газар дээрх ул мөр зэргийг мөшгөн шалгаж,
- Хил зөрчилт болон экспорт, импортын хууль бус үйлдэл гарсан эсэхийг шалгах үүрэгтэй.

Хууль бус экспорт, импорт илрүүлсэн тохиолдолд гаалийн бүрдүүлэлт хийх шаардлагагүй, гэмт хэрэг гэж үзэн, хуулийн дагуу шийдвэрлэнэ. Хилийн цэргийн байгууллага нь гэмт үйлдлийг илрүүлэх ба гаалийн үйл ажиллагаа явуулахгүй.

Үүнээс үзэхэд гаалийн ажлын хүрээнд хамрагдах нь гаалиас тогтоосон гарцаар нэвтрэх экспорт, импортын бараа бөгөөд үүнээс бусад нь хилийн цэрэгт харъяалагдана гэсэн хуваарьтай байна. Ямар ч гэсэн гааль хууль ёсны (их хэмжээний барааны урсгалтай хэсэг) гарцийг хяналт шалгалтандаа байлгаж, бусад нь хилийн цэргийн үүрэг болдог байна.

Зураг 4-6. Монгол улсын олон улсын ачаа барааны гол урсгал



Тээвэрлэлтийн талаас харвал Монголын ачаа тээвэрлэлт:

- БНХАУ-аар дамжих (Хятадын ачаа эсвэл Хонконг, Тайваниар дамжин импортлогдох ачаа) ачаа үндсэндээ төмөр замаар тээвэрлэгдэх
- ОХУ-ын талын ачаа төмөр зам, автомашинаар тээвэрлэгдэх гэсэн хэлбэртэй.

Хүснэгт 4-7. Ачааны урсгал / ачаа тээвэрлэлтийн ялгаатай байдал

	Ачаа гарах газар	Тухайн улсын дотоодын тээврийн хэрэгсэл	Монгол улсын дотоодын тээврийн хэрэгсэл
БНХАУ-ын ачааны зам	хятадын ачаа	төмөр зам	төмөр зам
	хятадын бус ачаа	төмөр зам автомашин	төмөр зам төмөр зам (ачаа шилжүүлэн ачина)
ОХУ-ын ачааны зам	оросын ачаа	төмөр зам автомашин	төмөр зам автомашин
	оросын бус ачаа	төмөр зам	төмөр зам

(1) БНХАУ-аас орж ирэх ачаа барааны урсгал

Хятадын боомтоор дамжин, бусад гадаад улсаас ирж буй ачаа Хятадын төмөр замаар тээвэрлэгдэн, Монголын төмөр замд шилжүүлэн ачигдаж, Улаанбаатарт хүрэн, тэндээ гаалийн бүрдүүлэлт хийгдэх нь нийтлэг.

Мөн Хятадын дотоодоос тээвэрлэгдэх ачаа шууд төмөр замаар тээвэрлэгдэх, автомашин болон төмөр замд шилжүүлэн ачих гэсэн 2 хэлбэртэй. Монголын талын авто замын дэд бүтэц хангалтгүйн улмаас Хятадаас төмөр замаар тээвэр хийхэд, өртөг, үр ашгийн талаас бодоход аль болох Хятадын дотоодоос шууд тээвэр хийх нь зардал бага байх ёстой ч,


- Хятадын төмөр замын тээврийн үйлчилгээ нь захиалга өгөхөд цаг их зарцуулдаг, хэмжээ бага. (Хятадын төмөр замын тээврийн нөхцөл байдлыг мэддэг хүний хувьд бол энэ нь туйлын зүй зохистой үнэлэлт. Гэвч, угаас олон улсын тээврийн давуу эрхээр бол, дотоодын тээвэртэй харьцуулахад олон улсын тээвэр нь өндөр үнэтэй байх ёстой.)
- Олон улсын төмөр замын тээврийн хөлсийг маш өндрөөр тогтоосон байдаг тул:

Олон улсын шууд тээврийн хөлс > Хятадын дотоодын авто тээврийн хөлс + хилийн боомт хүртэлх авто тээврийн хөлс + Монголын дотоодын төмөр замын тээврийн хөлс гэсэн хэлбэртэй болж байна.

(Японд бол төсөөлөхийн ч аргагүйгээр, олон чингэлэг ачаа энэ хэлбэрээр тээвэрлэгдэж байгаа нь дээрх зүйлийн баталгаа болно. Мөн хувиараа худалдаа арилжаа хийхээр явж байгаа хүмүүс ч шууд Эрээн явалгүйгээр, Замын-Үүдээс машинаар хил гарах аргыг сонгож байгаа нь олон улсын тээврийн хөлс харьцангуй үнэтэй гэж үзсэнийх биз ээ.)

Ийм шалтгаанаар олон ачаа бараа автомашинаас (Хятадын дотоод) / төмөр замд (Монголын дотоод) шилжүүлэн ачигдаж, тээвэрлэгдэж байна.

Зураг 4-8. БНХАУ □ Монгол Улсын хилийг нэвтрэх байдал




- Хятадаас төмөр замаар тээвэрлэгдэн ирсэн ачаа гаалийн хяналтан дор шилжүүлэн ачигдаж хил нэвтрэх боломжтой болно.
- Автомашины хувьд хил дээр экспорт, импортын бүрдүүлэлт хийгдэн, төмөр замд шилжүүлэн ачина.

Авто тээвэр нь Хятад улстай хиллэх боомт Замын-Үүдээс Улаанбаатар хот (зай: 700 км) хүртэл авто зам тавигдаагүй тул дотоодын бүх тээвэр төмөр замд тулгуурлахаас өөр аргагүй. (Автомашин хурд 30км/ц-аар хязгаарлагдана. Мөн шөнийн цагаар явах боломжгүй тул 2 өдөр илүү зарцуулна. (Төмөр замаар бол 1 өдөр).

Автомашингаар шууд тээвэр хийх боломжтой нь зөвхөн хилийн ойролцоох бүс нутаг.

Гэвч Хятад улсаас орж ирэх барааны автомашингаар тээвэрлэх хувь өсч буй бөгөөд 1) хил дээр бүрдүүлэлт хийх, 2) Улаанбаатарт бүрдүүлэлт хийх ачаа (Хилийн гааль гаалийн хяналтан дор явах ачаа эсэхийг нягтлана) гэж 2 хуваагдана.

Зураг 4-9. Замын-Үүдээр нэвтэрсэн барааны үнийн дүн (сая төгрөг)



Улаанбаатар хүртэлх тээвэр

①Хувь хүн болон бага хэмжээний барааны хувьд:

Хятад улсаас авто тээвэрээр ирсэн бараа хилийн гаалиар нэвтрэн, Замын-Үүдэд төмөр замд ачигдана. Цаашид Улаанбаатар хүртэл дотоодын тээвэр болж явна. Өөрөөр хэлбэл,

- Хятадын хил дээр экспортын бүрдүүлэлт хийн
- Монголын хил дээр импортын бүрдүүлэлт хийн (гаалийн татвар төлөн)
- Төмөр замын өртөө хүртэл автомашингаар тээвэрлэгдэн
- Галт тэргэнд ачигдана.
- Улаанбаатар хотод импортын бүрдүүлэлт хийгдэнэ.

Хувь хүн бол Хятадын хилээс автомашингаар тээвэрлэн ирээд, зорчигчийн галт тэргэнд гар тээш болгон ачих тохиолдол их.



Замын -Үүд дээр ачигдаж буй бага хэмжээний бараа

② Их хэмжээний барааны (нэгж: чингэлэг) хувьд:

Далайн тээврээр ирсэн чингэлэг гаалийн хяналтан дор тээвэрлэгдэн гаалийн хилээр нэвтэрч, төмөр замын тээвэр болно. Тухайлбал:

- Хятадын хил дээр экспортын бүрдүүлэлт хийн
- Монголын хил дээр гаалийн хяналтанд орон
- Төмөр замын өртөө хүртэл автомашинаар тээвэрлэгдэн
- Галт тэргэнд ачигдана.
- Улаанбаатар хотод импортын бүрдүүлэлт хийгдэх гэсэн хэлбэртэйгээрээ ① -ээс ялгаатай. Өөрөөр хэлбэл, хил дээр гаалийн бүрдүүлэлт хийдэггүй нь гол онцлог болно.

Хувь хүмүүсийн бага хэмжээний ачааны тухайд, дотоодын ачаа (импортын ачаа) болон гаалийн хяналтан доорх ачаатай холилдвол ачааг гаднаас нь хараад ялгах аргагүй тул гаалийн татвараас зайлсхийх зэрэг эрсдэл гарах магадлал их. Тийм учраас хил дээр гаалийн татварыг хураадаг байна. Харин чингэлэг зэрэг битүүмжлэгдсэн машинаар тээвэрлэгдэж буй (их хэмжээний ачааны хувьд) тохиолдолд гааль ачаанд тэмдэг тавина. Түүнийг нь хүрэх газарт нь шалгаснаар тээвэрлэлтийн үеийн ачааны бүрэн бүтэн байдал баталгаажигдана. Ингэснээр гаалийн бүрдүүлэлт хийхгүй байх нөхцөл бүрдэнэ.

Импортлогчдын хувьд аль болох хурдан ачаагаа авах сонирхолтой байдаг учраас өөрт ойр газар гаалийн бүрдүүлэлт хийхийг хүсдэг. Ялангуяа, Монголын хувьд өөрөө гаалийн бүрдүүлэлт хийлгэх нь их байдаг болохоор энэ тохилдол их байна (хил хүртэл явах шаардлагагүй). Үүнтэй уялдаад гаалийн хяналтан доорх тээврийн ач холбогдол их. Гэвч үүний тулд ачаа барааны бүрэн бүтэн байдлыг хангаж чадахуйц тээврийн хэрэгсэл, өөрөөр хэлбэл, төмөр замын тээврийн хувьд чингэлэг гэх мэтийн битүүмжлэлтэй зүйл хэрэгтэй байна.

(i) Төмөр замын тээвэр

Монгол, Хятадын төмөр замын өргөн өөр учраас хил дээр бараа шилжүүлэн ачих шаардлагатай болдог. Гэхдээ хил дээр импортын бүрдүүлэлт хийх шаардлагагүй, гаалийн хяналтан доорх ачаа болон зөвхөн бичиг баримтын шалгалт хийгдснээр хил нэвтрэнэ.(Импортын гаалийн бүрдүүлэлт Улаанбаатарт хийгдэнэ). Уг тээвэрлэлтийн үед Улаанбаатарт импортын бүрдүүлэлт хийх учир төмөр замын тээврийн манифестэд мэдүүлгийн үнийн дүнг тусган, экспортлогч талын үнийн нэхэмжлэхийг хавсаргадаг

зарчимтай. Ингэснээр Улаанбаатар хотын гаалийн газар мэдүүлгийн үнийг мэдэх боломжтой болж, мэдүүлгийн дүнг дарах зэрэг зүй бус үйлдэл хийх боломжгүй болох ёстой. Гэвч бодит байдалд ажлын арга барилаас ч, мөн эдгээр бичиг баримт нь ачаатайгаа хамт ирэх учир гаалийн зүгээс хянаж шалгах цаг бага, бичлэгийн алдаа илрүүлсэн ч засаж залруулах хугацаа байхгүй гэдэг үүднээс үр ашигтайгаар ашиглагддаггүй байв.

Энэ удаагийн гаалийн компьютерийн системээр хилийн гаалийн газрууд (УБ, Замын-Үүд, Сэлэнгэ) сүлжээгээр холбогдсноор, төмөр замын манифестын мэдээг УБ-т ачаа ирэхээс өмнө хүлээн авах боломжтой болно. Ингэснээр мэдүүлгийн мөнгөн дүнг нарийвчлан мэдэх явдалд ахиц гарна гэж найдаж буй.

Мөн, Хятадын тал чингэлэг дэх ачааг рентгэн туяагаар шалгах төхөөрөмж суурилуулсан (үүнээс гадна Манжуурт буй) нь хууль бус импортоос сэргийлэх нөхцлийг бүрдүүлж байна.

Төмөр замын терминал нь 1995 онд Японы олон улсын хамтын ажиллагааны агентлагийн тусламжаар баригдсан ба далайн тээврийн чингэлгийг шилжүүлэн ачих тоног төхөөрөмж ч суурилагдсан байна.

Төмөр замын терминал



Терминал дэх чингэлэг ачиж буулгах байдал



Гэвч далайн тээврийн чингэлэг гэх мэтийн том хэмжээний ачаа ачсан автомашины хувьд хилээс галт тэрэгний буудал хүртэлх зам нь маш муу, дээр нь энэ хоорондох тээвэр нь гаалийн хяналтан доорх тээвэр учраас гаалийн хяналт (машинаар дагалдах гэх мэт) зайлшгүй байх журамтай боловч, техник, тоног төхөөрөмжийн дутагдалтай байдлаас болоод, бодит байдал дээр гаалийн зуучлагчаар энэхүү үүргийг гүйцэтгүүлэхээс өөр аргагүй байдаг байна.

Терминал хүртэлх гаалийн зам



(ii) Авто тээвэр

Улаанбаатар хот хүртэл авто тээвэр хийх нь дэд бүтцийн талаас боломжгүй бөгөөд ойрх хил орчмын бүс нутгаар хязгаардлагдана. Автомашины хувьд ОХУ-тай хиллэдэг хилийн адилаар БНХАУ-ын автомашин явахыг хориглодоггүй. Харин одоогоор Хятадын тал Монголын автомашиныг Эрээн хүртэл явахыг зөвшөөрдөг ба түүнээс цааш бол шилжүүлэн ачих хэрэгтэй болно. Энэ хэсгийн замын ажилд маш их анхаарал тавьж байгаа ба Азийн Хөгжлийн Банк зэргийн F/S (нөхцөл боломжийн судалгаа) явагдаж байна.

Харин Хятадын тал өндөр чанарын (Asian highway) 4 эгнээ авто замыг хилийн боомт Эрээнээс нийслэл Бээжин хот хүртэл тависан байгаа нь энэ хоёр боомтын ялгааг тод харуулна. Мөн дээрх хэсгийн зам тавигдвал Орос Хятад хоёр улсыг холбосон олон улсын авто зам бий болох найдлага ч байгаа юм.

Гэвч, үүнийг гүйцэлдүүлнэ гэвэл:

- Улаанбаатар хүртэлх авто тээврийн гаалийн хяналтын системийг бий болгох
- Тээврийн компанийн мэргэжлийн зэрэг, тавигдах шаардлага зэргийн тогтолцоог бүрдүүлэх

гэсэн олон улсын бараа эргэлтийн нэгдсэн системийг бий болгох хэрэгтэй болно. Дэд бүтэц болон бараа эргэлтийн өнөөгийн байдлаар бол, энэ нь одоогийн тулгамдсан зорилт биш боловч цаашид анхаарах асуудал болгон авч үзэх шаардлагатай.

(iii) Хил нэвтрэх байдал (авто тээвэр)

Хил дээрх процедур нь ОХУ-тай хиллэдэг хилээс онцын ялгаагүй .

Хувь хүн болон жижиг аж ахуй эрхлэгч нь (чингэлэг хүрэхгүй хэмжээтэй, төмөр замын тээвэрт хамрах)

1. Импортлогч өөрөө хил дээр очин
2. Гаалийн зуучлагч байгууллагын төлөөлөгчийн газраар гаалийн мэдүүлэг бичүүлэх
3. Импортлогч мэдүүлэг, гаалийн татварын тооцоо зэргээ авч очин, гаальд мэдүүлэх
4. Барааны нэг бүрчлэсэн үзлэг хийлгэсний эцэст зөвшөөрөл авах

гэсэн хэлбэртэй байх бөгөөд барааны үзлэг шалгалт хийлгэх нь зайлшгүй. Гаалийн зуучлагч их хэмжээний ачааг (чингэлэгтэй ачааны машины хувьд) галт тэргэнд ачих хүртэлх гаалийн хяналтан доорх тээвэр болон бичиг баримт боловсруулалтыг хариуцан явуулж байгаа нь мэдүүлэг бичихээс илүү үйлчилгээ үзүүлж байгаа болох юм.

Хил дээр шилжүүлэн ачих шаардлагагүй барааны хувьд, экспорт импортын тус бүр 4 зам бүхий үзлэг, шалгалтын талбайгаар тоноглогдсон буюу ОХУ-тай хиллэдэг хилийн боомтоос илүү сайн нөхцөлтэй байна. Гэсэн хэдий ч хил нэвтрэх автомашины тоо харьцуулшгүй олон учир хилээр нэвтрэхэд илүү урт хугацаа шаардагдахаас өөр аргагүй байдаг байна. Мөн барааны үзлэг, шалгалт шууд зам дээр явагдахаар зохион байгуулагдсан байгаа нь ажил урагшлахгүй, бөөгнөрөл ачаалал үүсгэх магадлал их мэт санагдана.

Хил нэвтрэхээр хүлээж буй автомашинууд



Барааны үзлэг, шалгалт



(!) Ихэнх улс өөр улсын автомашин дотоодод тээвэр хийхийг зөвшөөрдөггүй. Энэ тохиолдолд тухайн улсуудын автомашин хил дээр ачаа шилжүүлэн ачих болдог. Харин Монголын хувьд зам тээврийн дэд бүтэц хангалтгүй тал ч бий учраас бусад улсын (ОХУ, БНХАУ) автомашиныг өөрийн улсын дотоодод тээвэр хийхийг зөвшөөрдөг аж.

(2) ОХУ-тай хиллэх хилийн байдал

(i) Төмөр замын тээвэр

Төмөр замын өргөн нь ОХУ-тай адил учраас ижил галт тэргээр тээвэр хийх боломжтой. Мөн гаалийн хяналтан дор хилээр нэвтрэх ч боломжтой. Төмөр замын тээврийн хувьд экспортлогч талын мэдүүлгийн үнийг ачааны манифестэд тэмдэглэх замаар мэдүүлгийн үнийг буруу бичих явдлаас сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлж байна.

(ii) Авто тээвэр

Улаанбаатар, Сүхбаатарын хооронд 2 эгнээ хатуу хучилтат замтай тул авто тээвэр хийх боломжтой (200 км замыг хагас өдөр орчимд). Энд ч ОХУ-ын автомашинд тээвэр хийхийг зөвшөөрдөг ба үнэхээр ч, замд Оросын автомашин Монголын автомашинаас олон тохиолдоно.

Монгол, ОХУ-ын хоорондох авто зам



Автомашины харъяалал



(iii) Хил нэвтрэх

Автомашинаар хил нэвтрэх нь маш бага бөгөөд хил нэвтрүүлэх байгууламж нь ч цомхон хялбар.

Хилийн хаалга



Барааны гаалийн үзлэгийн талбай



Авто тээврийн хувьд ОХУ-ын автомашин Монгол улсын нутаг дэвсгэрээр явахыг зөвшөөрсөн байдаг учир ачаа барааг шилжүүлэн ачиж буулгах байгууламж хэрэггүй, зөвхөн гаалийн хилээр нэвтрүүлэхийн тулд л шалгалт хийдэг цомхон газар байна. Энэ газар нь нэг зэрэг гурваас дээш автомашинд үзлэг хийх боломжгүй, мөн ил задгай талбай учир ажлын бүтээмжийн хувьд их зүйл хүсэх аргагүй. Эл байдалд дүгнэлт хийн, одоо гаалийн байгууллага өөрийн хүч хөрөнгөөр шинэ байгууламж барьж байна. Энэ байгууламж баригдснаар дэд бүтцийн хувьд томоохон дэвшилд хүрч чадах юм.

Шинээр баригдаж буй гаалийн байгууламж



Хил нэвтрэх процесс:

1. Импортлогч өөрөө хил дээр очих
2. Гаалийн зуучлагч байгууллагын төлөөлөгчийн газраар гаалийн мэдүүлэг бичүүлэх
3. Импортлогч мэдүүлэг, гаалийн татварын тооцоо зэргээ авч очин, гаальд мэдүүлэх
4. Барааны нэг бүрчлэсэн үзлэг хийлгэсний эцэст зөвшөөрөл авах

гэсэн хэлбэртэй байх бөгөөд импортлогч хил хүртэл өөрөө очих болон барааны үзлэг шалгалт хийлгэх нь зайлшгүй байдаг. Мөн гаалийн зуучлагч мэдүүлэг бичихээс өөр өндөр өртөгтэй үйл ажиллагаа явуулдаггүй учраас бодит байдал дээр импортлогч гаальд мэдүүлэх үйл явцын нэг тал болохоос өөр аргагүй байдаг байна.

Барааны үзлэг, шалгалт



Бараа олгох зөвшөөрөл авах хүртэл бараа нь хил дээр саатуулагдан, импортлогч хил, өөрийн компани хоёрын хооронд ирж, очин шаардлагатай бичиг баримт болон хэрэгцээт зүйлсийг бүрдүүлэх хэрэгтэй болдог.

Хил дээр саатуулагдсан автомашин



(3) Хилийн тээврийн онцлог

Хоёр хилийн байдлыг үзвэл системийн хувьд адил тал байгаа боловч нөгөө улстайгаа харьцах харьцааны түүхийн буюу эдийн засгийн байдлаас болон ихээхэн ялгаатай байдал ажиглагдана. ОХУ-тай хиллэх хилийн хувьд БНХАУ-аас ачаа барааны хэмжээ бага боловч түүхэн харьцаанаас уламжлан зам тээврийн дэд бүтэц сайн, шилжүүлэн ачилгүйгээр УБ хүртэл авто тээвэр хийх боломжтой (ОХУ-ын автомашин боловч). Хятадын хил дээрх дэд бүтэц сайн боловч шууд авто тээвэр хийхэд хүндрэлтэй. Зам / тээврийн хэрэгсэл солигдох явдал их гардаг. Мөн гадаад худалдааны хөгжлийг урьдчилан харвал, БНХАУ-тай хийх гадаад худалдаа улам бүр өргөжин тэлэхээр харагдаж байгаа бөгөөд эдүгээ Замын-Үүдийн дэд бүтцийн асуудлаас илүү эн тэргүүнд авч үзвэл зохистой нь хязгаарлалттай олон улсын ачаа эргэлтийн арга (төмөр зам, автомашины ачааг шилжүүлэн ачих шаардлагатай болдог зэрэг) ба төмөр замаар тээвэрлэн, УБ-т гаалийн бүрдүүлэлт хийдэг явдал нь дунд, урт хугацаанд голлох үүрэгтэй байх болно.

- **Ачаа барааны үзлэг шалгалтын ачаалал**

Аль ч хил дээр хил нэвтрэх саад бэрхшээл их, ачаа барааны үзлэг шалгалтанд цаг их зарцуулдаг. Хятадаас орж ирэх хил дээр бол зам дээр ачаа барааны үзлэг шалгалт явагдаж байгаа нь дэд бүтцийн хувьд асуудал байгааг харуулна. Хилийн бүс нутгийн байгалийн хатуу ширүүн нөхцөлд ил задгай талбайд үзлэг шалгалт хийнэ гэдэг амаргүй болох нь тодорхой. Аль болох үзлэг шалгалтын ачааллыг багасгах арга хэмжээ авах хэрэгтэй. Тийм ч учраас импортлогч гаалийн зуучлагчид хандснаас өөрөө хийх нь зардал бага гэж ойлгох нь нийтлэг ба хил дээр очин ачаа барааны үзлэг шалгалт хийлгэнэ. Цаашид олон улсын өрсөлдөөнийг нэмэгдүүлэхийн тулд олон улсын тээврийн нэгдсэн үйлчилгээг хөгжүүлэх талаар судалж үзэх шаардлагатай. Ялангуяа, хилийн гаалийн газар УБ-тай харьцуулбал гаалийн дэд бүтэц болон нөхцлийн хувьд ч хязгаарлалт хийхээс өөр аргагүй байдалтай байгаа ба цаашид авто тээврийн орон нутгийн гаалийн нэвтрэлт нэмэгдэх эрсдэл их байна.

- **Автомашинд зориулсан гаалийн нутаг дэвсгэр бий болгох**

Авто тээврийн хувьд нутгийн гүнд авто тээвэрт зориулсан гаалийн харъяаны тоноглол байхгүйн улмаас хил дээр гаалийн бүрдүүлэлт хийхээс өөр аргагүй байдаг талтай. Ийм тоноглол байвал авто тээврийн гаалийн бүрдүүлэлтийг хэрэглэгчид ойрхон газарт хийх боломжтой болно. Одоогоор дэд бүтэц зэрэг асуудлаас болоод төсөөлөхөд бэрх ч, цаашид

амьдрал ахуйд автомашин өргөн нэвтэрч буйтай холбогдуулан, авто тээврийг тооцсон хил нэвтрэх тогтолцоог бий болгох шаардлагатай.

4.3 Гаалийн байгууллагын өөрчлөлт шинэчлэлт

Монгол улсын гааль нь 1995 оноос ЮНКТАД-ын боловсруулсан гаалийн программ ASYCODA 2.6-ийг ашиглаж байв. 2000 оноос ашиглалтын хугацаа дуусан, одоо зөвхөн Улаанбаатар хотод хэрэглэж буй ч хэзээ зогсохыг мэдэхгүй байдалтай болжээ. Үүнийг шинэчлэн сайжруулахад 1.5 сая ам.доллар, 2 жилийн хугацаа шаардлагатай болж, энэхүү өөрчлөлтийг хийх аргагүй болсон учир өөрийн дотоод хүч бололцоогоор гаалийн программ хийн нэвтрүүлэхээр болсон байна.

Уг шинэ системээр мэдүүлгээс зөвшөөрөл хүртэлх программ, мөн үүндээ үндэслэн статистик мэдээллийн (импортлогч, экспортлогч, барааны нэр төрөл, хэмжээ, үнэ гэсэн мэдээллээс гаалийн татвар төлөлт хүртэлх мэдээллийг хадгалах) программыг ажиллуулж эхэлнэ. Үүн дотроос гаалийн бүрдүүлэлтийн автомат программыг эн тэргүүнд тавьж буй. Системийг 2002 оны 5, 6 дугаар сараас ажиллуулж эхлэхээр зорьж байсан боловч 2002 оны 11 дүгээр сараас эцсийн туршилтын ажиллагааг явуулахад хүрсэн байна. Энэ компьютерийн систем доорх 2 том зорилготой.

(1) Гаалийн бүрдүүлэлтийг автоматжуулах

Мэдүүлгээс зөвшөөрөл хүртэлх гаалийн бичиг баримтын шалгалтын хэсгийн ажлыг автоматжуулж буй. Мөн статистик мэдээлэл (мэдүүлгийн мэдээнээс гаргаж авсан) болвсруулалт ч энэ системийн хүрээнд явагдана. Гаалийн зуучлагчийн (мөн шууд харьцдаг ААНБ ч мэдүүлж болно) шивж оруулсан мэдээллийг шууд ашиглана (дахиж өөрчлөн шивж оруулах шаардлагагүй). Цаашилбал зөвшөөрөл, татвар төлөлтийг ч компьютерийн системээр явуулахаар зорьж буй. Гаалийн ажлын арга барилын хувьд 1 өдөр, түүнээс илүү ч хугацаа шаардагдаж байсан бичиг баримтын шалгалтыг 15 минут орчимд хийдэг болох зорилготой. Гэвч нөгөө талаас, одоогийн байдлаар ачаа барааны үзлэг шалгалтыг үгүй болгох бодлогыг тодорхойлоогүй, зөвхөн бичиг баримтын шалгалтаар зөвшөөрөл олгох талаар ойлголт тун нимгэн байна.

(2) Хилийн гаалийн газартай холбогдох (төмөр замын ачааны мэдээ илгээх)

Улаанбаатар хотын гаалийн газартай хилийн гаалийн газрууд сүлжээгээр холбогдон, харилцан мэдээ солилцож байна. Гол нь хилийн гаалийн газраас төмөр замаар тээвэрлэж буй ачааны мэдээг Улаанбаатарт хүлээн авахыг зорьж буй. Улаанбаатар, Сүхбаатар, Замын-Үүдтэй VSAT горимоор холбогдож, хилээр нэвтэрсэн төмөр замын ачааны манифестын мэдээг Улаанбаатарт тухайн ачаа хүрэхээс өмнө хүлээн авч чадсанаар, мэдүүлгийн үнийг үнэн зөвөөр мэдэж чадах учир маш чухал ач холбогдолтой юм. Уг нь төмөр замын манифестэд экспортлогч талын мэдүүлэг зэрэгт үндэслэсэн мэдүүлгийн үнэ тусгагдсан бйх ёстой. Гэтэл, бодит байдалд ажлын арга барилаас ч болоод, мөн эдгээр бичиг баримт нь ачаатайгаа хамт ирэх учир гаалийн зүгээс хянаж шалгах цаг бага, алдаа илрүүлсэн ч засаж залруулах хугацаа байхгүй гэдэг үүднээс үр ашигтайгаар ашиглагддаггүй байсан. Тийм ч учраас ачаа ирэхээс өмнө мэдээ авах нь их ач холбогдолтой юм.

Гаалийн татвар бүрдүүлэлтэнд бодит үнээс бууруулж мэдүүлдэг явдлыг арилгах нь чухал зорилт болдог тул одоогийн системээр хилийн гаалийн газартай холбогдон мэдээ авч чадах болсон нь мэдүүлгийн үнийг дарж мэдүүлэхээс сэргийлэхэд туйлын чухал арга болох юм.

① Систем нэвтрүүлэх ажлын явц

- (i) Улаанбаатар хотын гаалийн газрын шинэ системийн бүрдүүлэлтийн программын ажиллагаа жигдэрч байна. Систем дэх татварын программд засвар хийн, туршилтаар ажиллуулж буй. Статистикийн программыг мөн туршаад, үндсэндээ болж байна гэж үзсэн. УГЕГ-тайгаа on-line (шилэн кабель) горимоор холбогдсон нь саадгүй, хурд сайтай байгаа. Бусад жижиг программуудыг удахгүй ажиллуулна.

- (ii) Буянт-Ухаагийн гаалийн газрын программ ажиллаад жигдэрч байна. Гэвч УГЕГ-тайгаа сүлжээгээр холбогдож чадахгүй байгаа. Учир нь уг гаалийн газар хотоос хол, 2 уулын цаана нам дор газар байрлалтай болохоор модем ажиллахгүй. Энэ хооронд шилэн кабель байхгүй. Энэ асуудлыг шийдэх хэрэгтэй байна.
- (iii) Замын-Үүдийн гаалийн газрын систем ажиллаж эхэлсэн. Мэдээлэл бага багаар дамжиж байна. Гэхдээ бүрэн жигдрээгүй.
- (iv) Өнгөрсөн 7 хоногт Дархан, Эрдэнэт, Сүхбаатар, Алтанбулагийн гаалийн газарт систем нэвтрүүлэхээр болон, Алтанбулагаас бусад газарт программ суулган, холболт хийсэн. Өнөөдрөөс (11 сарын 18) эхлэн туршилтын журмаар ажиллуулсан, мэдээ авч эхлэнэ. Мэдээг Сүхбаатараас VSAT, Дархан, Эрдэнэтээс модемоор авахаар ажиллаж байна.

Систем ерөнхийдөө эрчимтэй хийгдэж байгаа ч алдааг нь засах, тохируулга хийх зэрэг олон ажил гарч байна.

② Систем ашигласны үр дүн

- Гаалийн бүрдүүлэлтийн цаг зарцуулалт багаар бодоход 2 цаг багассан.
- Гаалийн мэдээллийн үйл ажиллагаа хөнгөн шуурхай болсон. Завсрын алдаа гардаг нь байхгүй болсон. Мэдүүлгийг 3 удаа шивдэг байсан бол 1 удаа шивдэг болов.
- Мэдүүлэг шивж оруулах үүрэг гүйцэтгэдэг байсан байцаагч нар үнэлгээний байцаагч болсноор үнэлгээний ажлын үйл явц түргэн шуурхай болсон.
- Хяналт шалгалт сайжирсан. Бүрдүүлэлтийн явцыг удирдах хүмүүс шууд сүлжээгээр харж, хянаж чадах болсон ба байцаагч нарыг компьютерийн оноолтоор хуваарилдаг болсон.
- Бүх мэдээлэл богино хугацаанд УГЕГ дээр төвлөрдөг болсон байна.

(3) Гаалийн хилээр нэвтрэх үйл явцад гарч буй асуудал

① Гаалийн үйлчилгээний түргэн шуурхай байдал алдагдаж буй тухай

Гаалийн байгууллагын уг үндсэн үүрэг нь

- (i) Экспорт, импортын гаалийн бүрдүүлэлтийг түргэн шуурхай явуулах
- (ii) Зүй зохистой татвар хураах гэсэн хоёр талтай шаардлагыг биелүүлэх явдал юм. Харин татвар хураалт нь бэхжээгүй Монгол орны хувьд (ii) - д дурдсан тал дээр ихээхэн хүч зарцуулж байгаа нь бодитой үнэн билээ. Гаалийн татвар бүрдүүлэлт улсын татварын орлогын 40 хувийг эзэлдэг гэдэг нь бусад оронтой харьцуулахад ангид жишээ болох бөгөөд татвар бүрдүүлэх үүргийг улсын татварын албанд шилжүүлэх чиг хандлагыг баримталбал зохистой. Татвар бүрдүүлэхийн төлөө түргэн шуурхай үйлчилгээг орхигдуулах энэ байдал цаашид хэвээр үргэлжилбэл гадаадын хөрөнгө оруулалтыг татаж чадахгүйд хүрэх юм (өнөө ч уул уурхайн салбарт иймэрхүү бодит жишээ гарч байна). Гаалийн бүрдүүлэлтийн үйл явцыг дэлхий нийтийн стандарттай харьцуулахад онцын ялгаатай зүйл байхгүй, зүй ёсны чиг бодлого баримталж байгаа ч бодит үйл ажиллагаан дээр:
 - (iii) Бичиг баримтын шалгалтын явцад нэгж үнийн шалгалтыг хэтрүүлж хийн
 - (iv) Бүх бараанд үзлэг шалгалт зайлшгүй хийж байгаа нь уг бодлоготой нь үл нийцэх, чирэгдэл их, зардал өндөр үйл ажиллагаа юм. Гааль мэдүүлэг болон мэдүүлгийн агуулгын эрсдлийг тооцон дүгнэлт гаргах хэрэгтэй боловч энэ талаарх ойлголт ч байхгүй «бүх мэдүүлэг хуурамч, алдаатай» гэсэн үзлийг урьтал болгон хяналт шалгалт явуулдаг. Ер нь Монголын гаальд (буюу гаалийн байгууллагын удирдах түвшинд) Compliance-ийн (үйлчлүүлэгчийн санал хүсэлтийг хүлээн авах) талаар бодож үзэх явдал хангалтгүй байдгаас ачаа барааг нэг бүрчлэн шалгах шаардлага тавин, маш их цаг хугацаа заран, өндөр өртөг гаргаж байна.

Мөн ачаа барааны үзлэг шалгалтын үед ямар барааг шалгасныг гэрчлэх баримт үлдээдэггүй учир (ихэнх улсад үзлэг шалгалт хийсэн тэмдгийг тухайн ачаа бараанд тавин баталгаажуулдаг) ачаа барааны бүрэн бүтэн байдлын үүднээс ч, гадаад худалдаа

эрхлэгчдэд эргэлзээ төрүүлэхгүйн үүднээс ч глобал стандартад нийцсэн арга хэмжээ авууштай.

(iii), (iv)-ийг хэрэгжүүлэхдээ найдвартай мэдүүлэгчид илүү таатай нөхцөл урамшуулал (тухайлбал, гаалиар түргэн шуурхай нэвтрүүлэх) хэрэгтэй ч тийм систем бүү хэл, энэ талаарх ойлголт ч тун нимгэн байв. Гааль гадаад худалдаа эрхлэгчдийн талаар мэдээллийн сан үүсгэн байгуулж буй ч үүндээ үндэслэн дүн шинжилгээ хийх гэсэн эрмэлзэл бага байна. Эдүгээ өндөр хөгжилтэй орнууд хууль дүрмийг дээдлэн сахих үүднээс «найдвартай мэдүүлэгчид тэр хэрээр нь хөнгөвчлөсөн үйлчилгээ үзүүлэх» нь зүйд нийцнэ гэж үзэж байгаа билээ. Ийм чиг бодлого баримтлах нь гааль болон түүгээр үйлчлүүлэгч аль алинд нь ач холбогдолтой юм.

Өөрөөр хэлбэл:

- Гаалийн байгууллагын хувьд гүйцэтгэх ажлын хэмжээ багасах – ялангуяа, барааны үзлэг шалгалтанд шаардагдах хүн хүчний тоо буурна.
- Импортлогчийн хувьд гаалиар түргэн нэвтрэх боломжтой болно. Мөн нийгмийн хувьд авч үзсэн ч хөрөнгө мөнгө, цаг хугацаа хэмнэгдэх ач холбогдолтой.

Гаалийн зуучлагч, импортлогч, гаалийн байгууллагын харилцаа

Монголын хувьд, гаалийн зуучлагчаар төлөөлүүлэн бүрдүүлэлт хийх зарчимтай ч, зуучлагч зөвхөн мэдүүлэг бичин, бичиг баримтыг гаалийн байгууллагад өгөхөөс ачаа бараагаа татаж авах хүртэлх бүх ажлыг импортлогч өөрөө хийж гүйцэтгэх нь нийтлэг байна. Өндөр хөгжилтэй оронд бол ачаа барааг татаж авах хүртэлх ажлыг гаалийн зуучлагч хийж гүйцэтгэдэг бол Монголд тийм биш. Бүрэн үйлчилгээг хийлгэсэн тохиолдолд хөлс нь бараг 10 дахин өсдөг болохоор тийм байдаг болов уу. Харин зуучлагчаар бүрэн үйлчилгээ хийлгээгүй тохиолдолд импортлогч нь гаалийнхантай янз бүрийн байдлаар ярьж тохиролцох, эцэст нь «мөнгөөр» асуудлыг шийдвэрлэх гэсэн хандлага гардаг ба энэ нь гаалийнхны авилгал, хээл хахуулийн асуудлын эх үүсвэр болдгийг үгүйсгэхгүй. (Монголын гаалийнхны дунд хууль бус үйлдэл гардаг ч, импортлогчдын зүгээс ч хууль бус үйлдлийн эх үүсвэрийг тавьдаг болохыг онцолж дурьдмаар байна).

Хүснэгт 4-10. Гаалийн зуучлагчийн үйлчилгээний хэлбэрийн давуу болон дутагдалтай тал

	Зөвхөн мэдүүлэг бичдэг үйлчилгээ (А)	бүрэн үйлчилгээ (Б)
Экспортлогч, импортлогчийн хувьд	<ul style="list-style-type: none"> • Зардал бага гарна • Өөрийн биеэр гааль дээр удаан хугацаагаар байх шаардлагатай 	<ul style="list-style-type: none"> • Зардал өндөр • Төвөг чирэгдэлгүй • Үнэн шударга бүрдүүлэлт хийхэд хялбар
Гаалийн байгууллагын хувьд	<ul style="list-style-type: none"> • Ажиллагаа ихтэй • Хууль бус үйлдлийн үндэс болно 	<ul style="list-style-type: none"> • Үйлчлэхэд хурдан шуурхай амар хялбар болно • Хууль бус үйлдэл хийх боломжгүй болно • Хүн хүч, ажлын хэмжээ буурна
Гаалийн зуучлагчийн хувьд	<ul style="list-style-type: none"> • Хөрөнгө оруулалт хийх шаардлагагүй (жижиг аж ахуйн нэгж ч эрхлэх боломжтой) 	<ul style="list-style-type: none"> • Орлого нэмэгдэнэ • Хөрөнгө оруулалт хийх шаардлагатай

(тайланг бичигч нэгтгэв)

③ Импортлогчийн талаарх мэдээллийн мөрөөр шалгах шаардлагын тухай

Ихэнх улс оронд ачааг татан авсны дараа гаалийн татварыг тодорхойлох дахин шалгалтын (аудит) хугацааг тогтоосон байдаг (импортлогчийн зүгээс ч гаалийн татварын талаар санал нийлэхгүй зүйл байвал дахин шалгалт хийхийг шаардаж болно). Ингэснээр гаалийн байгууллага нь импортын зөвшөөрөл олгосны дараа ч гаалийн татварын орлогын зөрүүг зохицуулах (буцааж төлөх тохиолдол ч байна) боломжтой болно. Ийм тогтолцоогүй бол импортлогдсон яг тухайн үед гаалийн татварыг 100% тодорхойлох шаардлага тавигдах бөгөөд энэ нь цаг хугацаа, хүч хөдөлмөрийн хувьд маш хүндрэлтэй юм. Монголд, бүрдүүлэлтийн дараахь шалгалтаар дахин тогтоосон гаалийн татварын хэмжээ нь нийт гаалийн татварын 0.25%-иас хэтэрдэггүй. (Үүгээр 2 тэрбум төгрөгийн орлого оруулсан байна).

Хэрвээ дахин шалгалтын тогтолцоог бүрдүүлж чадвал, гаалийн үйлчилгээний түргэн шуурхай байдалд томоохон дэвшил болно. Үүний тулд, импортлогчийн бүрдүүлэлтийн дараахь оршин байгаа хаягийг магадлан тогтоох шаардлагатай. Ингэхээр, УТЕГ-аас мэдээлэл ((тухайн импортлогч (ААНБ, хувь хүн) нь бодитойгоор оршин байгаа юу үгүй юү, эсвэл оршин байгаа хаяг нь зөв эсэх тухай)) авах нь маш их ач холбогдолтой. Энэ нь ногдуулж чадаагүй татварыг нөхөн хураахад чухал үүрэгтэй мэдээлэл болох юм. УТЕГ-ын хувьд УГЕГ-аас авах мэдээлэл нь туйлын чухал мэдээлэл байх бөгөөд УГЕГ-ын хувьд ч УТЕГ-аас мэдээлэл авч, харилцан уялдаатай ажиллах нь үр дүнтэй билээ. УГЕГ-ын хувьд гаалийн татварын орлогыг нэмэгдүүлэхийн тулд ч, найдвартай үйлчлүүлэгчдийг оновчтой сонгож хөнгөлөлт үзүүлэхэд ч УТЕГ-аас авах мэдээллийг үр дүнтэй ашиглах талаар судалж үзэх шаардлагатай.

(4) Дэвшүүлэн тавих санал

① Компьютерийн систем нэвтрүүлэлт, түүний үр өгөөж

Олон улсын ачаа эргэлтийн урсгалыг бодоод үзэхэд, үнэхээр их хэрэглэгчтэй газар болох Улаанбаатар хотод гаалийн үйл ажиллагааг хэрхэн үр ашигтай явуулах вэ гэдэг нь хамгийн чухал биз ээ. Энэ жилийн судалгааны чиглэлийн хувьд олон улсын нийтлэг зарчмыг харгалзан үзэж, гаалийн татвар бүрдүүлэх тогтолцоог дэмжихийн зэрэгцээ гаалийн үйл ажиллагааны түргэн шуурхай байдлыг хөгжүүлэхэд «найдвартай аж ахуйн нэгж байгууллагыг ялгаж сонгох» бодлогыг авч үзвэл ач холбогдолтой.

Өнгөрсөн жилээс эхлэн УГЕГ нь өөрийн улсын дотооддоо компьютерийн мэдүүлгийн систем хийлгэж байгаа бөгөөд систем нэвтэрснээр гаалийн дотоод ажлын үр дүнд ахиц дэвшил гарах нь эргэлзээгүй боловч энэ үр дүн нь хязгаарлагдмал байх нь гарцаагүй. (компьютерийн мэдүүлэгт шилжсэн ч ачаа барааны нэг бүрчлэсэн үзлэг шалгалт шаардлагатай хэвээр байна). Одоо нэвтрүүлж буй компьютерийн системээр мэдүүлэг дэх мэдээллийг компьютерт шивж оруулах ажлыг хувийн хэвшлийнхэнд шилжүүлснээр гаалийн зүгээс гүйцэтгэдэг ажлын ачаалал багасах ч,

- Ижил төрлийн бүтээгдэхүүн байсан ч үнэ ялгаатай бол тэр хэвээр компьютерт оруулж байгаа нь түрүүчийн хүний хийсэн үйлдлийг тэр чигээр нь давтаж байгаа болох ба ажлыг хөнгөвчилж хялбаршуулж байгаа хэрэг биш.
- Мэдүүлэг дэх үнийн дээд, доод хэмжээг автоматаар тооцоолон түүнд нь тохируулан үнэлэлт өгөх бүтэц зохион байгуулалт байхгүй байна.
- Үүнтэй адилаар импорт, экспорт мэдүүлэгчдийн талаарх мэдээлэлдээ тулгуурлан найдвартай мэдүүлэгчийг ялгаж тогтоох зүйл ч байхгүй. (Энэ тухай техникийн бодлогын даалгаварт тусгагдаагүй.)


гэх мэтээр компьютерт мэдээлэл оруулаад, түүндээ үндэслэн үйл явцад үнэлэлт дүгнэлт хийх функцын талаар хараахан авч үзээгүй байна. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд мэдүүлэгчийн ажлын амжилт, бараа болон мэдүүлэг дэх бусад агуулгын эрсдлийг тодорхойлохын тулд Risk management-ийг гаалийн системд авч хэрэгжүүлэх шаардлагатай ба энэ асуудлыг шийдвэрлэхгүй байхын хэрээр ачаа барааны үзлэг шалгалтын системийн хоцрогдмол байдал үргэлжилсээр байх болов уу.

Бичиг баримтын шалгалтыг түргэн шуурхай хийх, ачаа барааны үзлэг шалгалтыг

хөнгөвчлөхийн тулд найдвартай мэдүүлэгчид зохих таатай нөхцөл олгох арга хэмжээ авах хэрэгтэй. Уг нь гаалийн байгууллага өөрт буй экспортлогч, импортлогчийн талаарх мэдээллийн сангаа ашиглан учир холбогдлыг тогтоох, магадлан шалгах боломжтой. Энэхүү учир холбогдлыг тогтоох, магадлан шалгах системийн хувьд өндөр хөгжилтэй орноос технологийн тусламж дэмжлэг авах бололцоотой. Мөн гаалийн автоматжуулсан шинэ системийн түргэн шуурхай, таатай нөхцөл байдлыг нэмэгдүүлэхийн тулд ч системийн тал дээр технологийн хамтын ажиллагаа явуулах боломжтой юм. Гаалийн хувьд автомат мэдүүлгийн системийн үр дүн нүдэнд харагдахуйц болж ирсэн (хуудас 21 үз) ба риск менежментийг нэвтрүүлэх учир холбогдол болон ухагдахууныг ойлгон ухамсарлах үндэс суурь тавигдаж эхэлсэн. Үүн дээр компьютерийн системийг өөрийн хүчээр хийж бүтээсэн гэдэг том амжилт байгаа бөгөөд Монголын гаалийн байгууллагын хувьд риск менежмент гэдэг нь тийм ч ахадсан хүсэлт огт биш юм. Энэ систем нэвтэрвэл хэрэглэгчийн зүгээс харсан ч

- Найдвартай импортлогчид гаалийн түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх урамшууллын тогтолцоо бий болох
- Ачаа барааны үзлэг шалгалтын ачааллыг бодитойгоор бууруулах боломжтой болон өртөг, цаг хугацааг хэмнэх давуу талтай.

Зураг 4-11. Риск менежмент нэвтрүүлэхийн үр ашиг



② Гаалийн ажилтны хууль бус үйлдлээс сэргийлэх тухай

Монголд ч, ялангуяа гаалийн ажилтны хууль бус үйлдэл, «ширээн доогуурх тохиролцоо» зэрэг асуудал байна. Хөгжиж буй орны хувьд төрийн байгууллагын ажилтан, ажиллагсдын цалингийн түвшин доогуур байгаа нь томоохон асуудал болох ба гаалийн хувьд ч ялгаагүй. Ажилтан, ажиллагсдын цалингийн түвшинг дээшлүүлэх, урамшууллын системийг нэвтрүүлэх хэрэгтэй ч энэ нь тийм амар шийдэгдэх асуудал биш. Гэвч компьютерийн систем нэвтэрснээр хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох ажилд ахиц гарна гэж найдаж болно. Угаас хэрэглэгч нь ачаа бараагаа аль болох түргэн авахыг хүсдэг. Гэтэл, гаалийн бүрдүүлэлтэнд цаг их зарцуулах учир тусгай хөлс төлөх болдог нөхцөл шалтгаан байгаа учир гаалийн үйлчилгээг түргэн шуурхай болгох нь юуны түрүүнд хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ болох юм.

Мөн үйл ажиллагааг автоматжуулснаар хүний хүчин зүйл нөлөөлөх зүйл бага болох нь ойлгомжтой. Мэдүүлэгчтэй нүүр тулан ажиллах боломж багасахын хэрээр хууль бус үйлдэл хийх нөхцөл боломж хумигдана. Бодит газар дээр нь очиж үзсэнээр бол, олон ажилтан нэг дор байх тул бичиг баримтын шалгалтын явцад хууль бус үйлдэл гарах нөхцөл бага гэж үзэж болох ба харин ачаа барааны үзлэг шалгалтын үед, мэдүүлэгч, гаалийн ажилтан хоёр харьцах болно. Мөн бараа нь ч нүдний өмнө ил байгаа тал ч байх тул хууль бус үйлдэл гарах нөхцөл илүү их гэж үзэхээс өөр аргагүй. Ачаа барааны үзлэг шалгалт багасвал хууль бус үйлдэл гарах нөхцөл багасна. Мөн

- Хэрэглэгчийн хувьд ч ачаа барааны үзлэг шалгалт багасвал түргэн шуурхай үйлчлүүлж, иймэрхүү хууль бус үйлдлээс зайлсхийж чадах юм. Тийм ч учраас «үнэн зөв мэдүүлвэл ачаа барааны үзлэг шалгалт багасна» гэсэн урамшууллыг өгөх нь туйлын чухал билээ.

- Мөн нөгөө талаас ачаа барааны үзлэг шалгалтыг олон байцаагч хамт хийдэг болох арга ч бий.

Гэвч хөгжиж буй орнуудын дунд үзлэг шалгалтыг дор хаяж 2 хүн хийдэг болготол, харин ч төлөх мөнгө нь 2 дахин ихэссэн гэсэн жишээ байгаа бөгөөд энэ арга хэмжээг нэвтрүүлэх нь эрсдэл ихтэй юм.

- Түүнчлэн гаалийн программд гаалийн ажилтны бүртгэлийг (хариуцагч, ажил эхлэх, дуусах болон ажилласан цаг, гаалийн хилээр нэвтрүүлсэн барааны нэр төрөл зэрэг) хянаж чадах функцыг оруулж өгөх талаар ч бодох хэрэгтэй. Үүндээ үндэслээд ямар нэгэн өөр мэдээлэл гарсан тохиолдолд хяналт шалгалтын салбарынхан тухайн ажилтны үйл ажиллагааг мөшгөн шалгадаг тогтолцоог нэвтрүүлснээр, ажилтнуудын ухамсар, ёс зүй дээшлэх боломжтой болно. Мөн ийм тогтолцоо бий болсныг бүгдэд мэдүүлэх төдийд ч гаалийн ажилтны хууль бус үйлдлийг таслан зогсооход томоохон үр дүн авчирна.

③ Бүрдүүлэлтийн дараахь шалгалтын үүрэг

Монголд бүрдүүлэлтийн дараахь шалгалтаар засаж залруулсан мэдүүлэг ердөө 1хувь хүрэхтэй үгүйтэй байна. Энэ үүргийг бүрэн хэрэгжүүлж чадвал гаалийн татвар хураалт нэмэгдэхийн зэрэгцээ гаалийн хилээр нэвтрэх үеийн үйлчилгээ ч түргэн шуурхай болно (Монголд бүрдүүлэлтийн дараахь шалгалт явуулахад хүндрэлтэй тул импортоор орж ирэх үед нь 100% татвар ногдуулах шаардлагатай болдог. Үүний улмаас нарийн чанд үзлэг шалгалт хэрэгтэй болон, цаг хүч зарцуулна. Хэрэв бүрдүүлэлтийн дараахь шалгалтын үүрэг нэмэгдвэл импортлох үеийн ажлын ачаалал багасах боломжтой). Үүний тулд импортлогчийн оршин буй хаягийг тодруулан мэдэх шаардлагатай. Одоо ҮТЕГ-тай сүлжээгээр холбогдон мэдээлэл солилцох болсноор импортлогчийн оршин буй хаягийг мэдэж чадах болно. ҮТЕГ-аас хувь хүн импортлогчийн хувьд, найдвартай татвар төлөгчид л гадаад худалдаа эрхлэхийг зөвшөөрөх арга хэмжээ авах гэж байгаа тул зөвшөөрлийн хугацааг шинэчлэх эсвэл тодорхой хугацаанд хаягийг шалгах зэрэг аргаар аль болох шинэ, үнэн бодит хаягийн мэдээллийг ҮТЕГ-т дамжуулах хэрэгтэй.

Нисэхийн гаалийн газар ҮТЕГ-аас авсан мэдээллээр шинэ хаягийг тогтоох аргагүй тул өөрсдөө импортлогчдын талаарх мэдээллийн сан үүсгэн байгуулж буй байдалтай байв. ҮТЕГ-ын илүү их хүчин чармайлт хэрэгтэй санагдана.

④ БНХАУ-ын гаалийн байгууллагатай хамтран ажиллаж буй байдал

Экспортлогч талын гаалийн байгууллагатай нягт хамтран ажиллаж чадвал импортлогч талын гаалийн байгууллагын хууль бус импортыг илрүүлэх зэрэг ажилд тун чухал ач холбогдолтой. Үнэхээр 2001 он хүртэл спиртийн хууль бус импорт асуудал болж байсан Монголын гаалийн хүсэлтийн дагуу Хятадын гааль хяналт шалгалтаа чангатгасны хүчинд хууль бус экспорт нь буурсан бодит жишээ ч байна. Мөн БНХАУ-ын хилийн боомт Эрээний төмөр замын буудал дээр чингэлэгтэй ачааг тэр чигээр нь шалгах рентген төхөөрөмжийг 2002 оноос эхлэн ажиллуулах болсон нь ачааг шалгахад маш хялбар болсон байна. Улмаар Хятадын талын экспортын мэдүүлгийн хуулбар буюу мэдээллийг Монголын тал импортын үед хэрэглэвэл, илүү дутуу мэдүүлэх явдал онолын хувьд байхгүй болох юм (экспортын мэдүүлэгт үнэн зөв экспортын үнийн дүн байх тул импорт мэдүүлэхийн тулд хуурамчаар үйлдсэн үнийн нэхэмжлэх хийх боломжгүй болно). Мөн хоёр талын хилийн гаалийн газар ойрхон орших учир бичиг баримт солилцох ажилд хүндрэл учрахгүй. Харамсалтай нь Хятадын гаальд ч хээл хахууль, хууль бус үйлдэл их байх тул бүх мэдүүлэг үнэн зөв байх аргагүй ч, хоёр гаалийн байгууллагын хооронд энэ талаар хэлэлцэн ярилцаж байгаа ба илүү их хүчин чармайлт шаардлагатай мэт санагдана.

Боломж 1.

- Хятадын гаалийн экспортын мэдээ баримтанд жинхэнэ Transaction Value (борлуулалтын үнэ)-г тэмдэглэсэн байх ба түүнтэй харьцуулан тулгавал мэдүүлгийн үнийг үнэн зөв тогтоож чадна. Ингэснээр монголын гаальд үнийг хэтэрхий дарж мэдүүлэх боломжийг хааж чадна.
- Нөгөөтэйгүүр,
 - Гаргаж болохгүй зүйл гарч багаа нь Хятадын талд мэдэгдэнэ.
 - Оруулж болохгүй зүйл орж байгаа нь Монголын талд мэдэгдэнэ гэдгээс үүдээд энэ ажлыг хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй байна.Хятадын талтай хамтран ажиллах талаар хэлэлцэн ярилцаж буй.

4.4 Цаашид шийдвэрлэвэл зохих асуудал

Олон улсын ачаа эргэлтийн систем болон гаалийн байгууллагын уялдаа холбоо

Эх газрын улс – Монгол орны хувьд, БНХАУ, ОХУ-аар дамжиж тээвэр хийхгүй бол олон улсын өрсөлдөөнд ихээхэн хохирол амсана. Монгол улсад экспортын бараагаа олон улсын зах зээлд хүргэх хямд тээврийн хэрэгсэл байхгүй, «хил дээр дамжуулж өгөх» хэлбэр голчлох тул олон улсад өрсөлдөх чадвар маш сул байдалтай. Гааль болон улсын хилээр нэвтрэх үеийн саад тотгорыг багасгаж, хэрхэн олон улсын ачаа эргэлтэд таатай орчин бүрдүүлэх вэ гэдэг нь одоо тулгамдсан асуудал биш боловч цаашид Монгол орны эдийн засгийн хөгжлийн төлөө орхигдуулж боломгүй чухал асуудлын нэг мөн.

Гааль, гаалийн бүрдүүлэлтийн талаас харсан ч

- Гаалийн бүрдүүлэлтэнд зарцуулах хугацаа
- Ачаа барааны үзлэг шалгалтын хэрэгжилт
- Хил дээрх авто тээврийн асуудал зэргийг гаргаж тависан билээ.

Эдүгээ Монгол улсад гаалийн бүрдүүлэлтийг хамруулсан бүрэн үйлчилгээ үзүүлэх ААНБ бараг байхгүй (мөн гадаад худалдаанд оролцогчид ч гадны байгууллагаар хийлгэснээс өөрөө хийх нь өртөг бага гэсэн ойлголттой байх нь нийтлэг), цаашид хэрхэн хувийн хэвшлийнхний үйлчилгээний системийг бүрдүүлэн гаалийн байгууллагатай хамтран ажиллуулах вэ гэдэг нь чухал асуудал юм.

Хилээр нэвтрэх үйл явцын тухайд, ялангуяа, авто тээвэр эрчимтэй хөгжвөл гааль болон тээвэрлэлтэнд дараахь асуудал урган гарч ирэх болно.

«Гааль»

Тухайн улс хөгжиж буй орон байх тусам улсын татварын орлого гаалийн татварын орлогод тулгуурлах нь их байх ба хил дээр гаалийн татварыг хурааж авахаас өөр аргагүй байдаг. Мөн эдгээр орнуудад ихэнх тохиолдолд бүрдүүлэлтийн дараах шалгалтын систем бүрдээгүй байдаг тул ачааг тодорхой мэдэж чадах (ачаа нүдний өмнө харагдаж байх) шатанд гаалийн бүрдүүлэлт хийх нь татвар бүрдүүлэх талаас бол хамгийн үр дүнтэй байдаг нь үнэн юм.

Гэвч, цаашид авто тээврийг бодоод үзвэл, Улаанбаатар хот зэрэг нутгийн гүнд авто тээвэрт зориулсан гаалийн нутаг дэвсгэр болон тоноглол бий болгох шаардлагатай болох биз ээ (үйлчлүүлэгчид ачаа бараа нь ойр байх тусам хил дээр бүрдүүлэлт хийлгэснээс илүү таатай нөхцөл болж, сайнаар үнэлэгдэх боломж их байх юм). Энэ тохиолдолд хилээс гүний гаалийн нутаг дэвсгэр хүртэлх тээвэр нь гаалийн хяналтан дор байх шаардлагатай ба хэрхэн энэ тогтолцоог бий болгох вэ гэдгийг зөвхөн гааль төдийгүй гаалийн зуучлагч, тээвэрлэгчийн ажил үйлчилгээний агуулга хүрээг хамруулан, нэгтгэн авч үзэх шаардлагатай. Ялангуяа, гаалийн хувьд эрсдлээс хамгаалах функц хэрэгтэй. Европын TIR Карнэ тээврийнх шиг бүтэц хэрэгтэй болох ба энэхүү баталгаат системийг бий болгоход хөрөнгө мөнгөний хуримтлал гэсэн хүндрэл бэрхшээл байгаа хэдий ч чухал асуудал юм.

«Тээвэр»

Монгол улсын хувьд өөрийн орны нь авто тээврийн салбар хөгжөөгүйн улмаас дотоодын тээвэрт нь ОХУ болон БНХАУ-ын авто тээвэрт хүртэл тулгуурлах явдал ч байна. Олонхи оронд харилцан тэгш эрхтэй байх зарчмын үүднээс, «ямар ч улсын автомашин нөгөө улсын нутаг дэвсгэрээр явж болно» гэдгийг, эсвэл каботажийн дагуу улс доторх тээврийг зөвхөн өөрийн орны үйлдвэрлэгчдээр хязгаарлах арга хэмжээ авсан байдаг ба Монгол улсын энэхүү тохиолдол нь глобаль стандартын үүднээс авч үзвэл ховор тохиодол болно. Энэ нь өөрийн орны тээврийн хөлс гадны байгууллага руу урсаж буйг илтгэнэ. Цаашид олон улсын тээвэрт өөрийн орны тээврийн салбарыг хэрхэн авч явах вэ гэсэн ерөнхий суурь төслийг боловсруулах хэрэгтэй. Гаалийн зүгээс харахад, гаалийн баталгаат байдлын үүднээс авто тээвэр эрхлэгчдэд тавигдах шаардлага, мэргэжлийн зэрэг зэргийн талаар судалж үзэх шаардлагатай.

Дээрх асуудлууд нь гаалийн байгууллага дан ганцаар шийдвэрлэх зүйл биш бөгөөд өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хэрэгтэй. Монгол улсын гаалийн байгууллага өөрийн дотоод хүч бололцоогоор компьютерийн систем нэвтрүүлж, томоохон амжилт гаргаж байна. Цаашид олон улсын худалдааг хэрхэн саад бэрхшээлгүй, эрчимтэй болгох вэ гэсэн том зорилтыг хэрэгжүүлэхийн төлөө хүчин чармайлт тавих нь зүйтэй. Үүний тулд дан ганц гаалийн өөрчлөлт шинэчлэлт биш олон улсын ачаа эргэлтэнд хамрагдах бүхнийг нэгтгэсэн, Монгол улсын хөгжлийн төлөө гэсэн өргөн хүрээнд авч үзэх шаардлагатай. Гаалийн байгууллагад ч илүү өргөн хүрээнээс хандсан бүтэц зохион байгуулалт хэрэгтэй билээ.

ТАВДУГААР БҮЛЭГ

ТАТВАРЫН АЖИЛТНЫ СУРГАЛТ

5.1 ҮТЕГ-ын сургалтын түүхэн үүсэл хөгжил ба өнөөгийн байдал

Татварын албаны сургалтын байдлыг он дарааллаар авч үзвэл дараах байдалтай байна.

1993 он

Татварын албаны ажилтнуудын мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэх асуудалд анхаарч ҮТЕГ-ын даргын 1993 оны 9 сарын 24-ний өдрийн шийдвэрээр Сургалтын төв байгуулж, 2 орон тоотойгоор ажиллуулж эхэлсэн.

Анхны сургалтуудыг татварын байцаагч нарыг мэргэшүүлэх чиглэлээр нягтлан бодох бүртгэл, хяналт шалгалтын асуудлаар мэргэжил дээшлүүлэх сургалтыг Санхүү эдийн засгийн коллежтэй хамтран зохион байгуулж, нийт Улаанбаатар хотод ажиллаж байсан 150-иад байцаагч сургалтанд хамрагдсан нь тухайн үед ажиллаж байсан татварын нийт ажилтнуудын 15 хувийг хамарсан байна.

Сургалтын эхний шатанд АНУ, Австри, Герман, Турк, Япон, Тайвань, Өмнөд Солонгос зэрэг улсад давхардсан тоогоор 30 орчим удирдах ажилтан, татварын байцаагч нарыг сургалтад хамруулж байжээ.

1994 он

Энэ жил нь татварын чиглэлээр нарийн мэргэжлийн үндэсний боловсон хүчин бэлтгэх, давтан сургах талаар баримтлах бодлогоо тодорхойлж, түүний суурь арга хэмжээг авч эхэлсэн онцлогтой он байсан.

Боловсролын асуудал хариуцсан төрийн төв байгууллагатай зөвшилцөн, Сургалтын төрийн сангийн зээлийг ашиглан хөдөө орон нутгийн 50 оюутныг МУИС, Мандах дээд сургууль, Эдийн засгийн коллежд суралцуулах ажлыг зохион байгуулсан байна. Мөн төв, орон нутгийн татварын албадад ажиллаж байгаа санхүү, эдийн засгийн дунд мэргэжилтэй болон санхүү, эдийн засгийн бус дээд мэргэжилтэй 99 байцаагчийг үүрэгт ажлаас нь хөндийрүүлэхгүйгээр дээр дурдсан их, дээд сургуулиудад орой, эчнээ салбарт элсүүлэн татварын байцаагч, нягтлан бодогч мэргэжилтэй болгох чиглэлээр зохих арга хэмжээ авсан нь татварын албыг мэргэжилтэй боловсон хүчнээр хангахад маш чухал алхам болсон.

Түүнчлэн хөдөө орон нутагт сургалтын төвийн орон тооны 2 багш, ҮТЕГ-ын бусад хэлтсийн туршлагатай ажилтнуудын хүчийг ашиглан бүх аймаг, сумдын байцаагч нарыг хамруулсан мэргэшил дээшлүүлэх 72 цагийн хөтөлбөртэй 28 сургалтыг зохион байгуулж 806 байцаагчийг хамруулахдаа орон нутгийн байцаагч нарын мэргэшлийн түвшинг тогтоож, 68 байцаагчид шинээр мэргэшлийн зэрэг олгох, мэргэшлийн зэрэг ахиулах арга хэмжээнд хамруулсан нь үр дүнтэй арга хэмжээний нэг болжээ.

Энэ үед гадаад сургалтанд байцаагч нарыг хамруулах ажлыг нэлээд өргөн хүрээнд зохион байгуулж байжээ. Тухайлбал Олон улсын хамтын ажиллагааны хөгжлийн байгууллагын хөрөнгөөр санхүүжилт хийгдэн нийт давхардсан тоогоор 22 ажилтан Турк, Австри, Дани, Унгар, Тайваньд семинар, уулзалт, зөвлөгөөнд оролцсон байна.

Үндэсний татварын албаны өөрийн хөрөнгөөр ОХУ, БНХАУ-д 40 орчим хүнийг туршлага судлуулах чиглэлээр сургалтанд хамруулсны 67 хувь нь хөдөө орон нутгийн татварын албаны ажилтнууд байсан байна.

Татварын албаны ажилтнуудад гадаад хэл дээрх мэргэжлийн холбогдолтой материалтай харьцах, ашиглахад хэлний бэрхшээл гарч байснаас улбаалан дүгнэлт хийж 28 ажилтныг англи хэлний сургалтанд хамруулсан нь цаашид гадаад сургалтанд хамруулах байцаагч нарын хэлний талаар учирч байсан хүндрэлийг арилгах эхлэл болсон байна.

Сургалтын төвийн материаллаг баазыг бэхжүүлэх, сургалтанд хамрагдагдсыг хичээллэх боломжоор хангахад анхаарч Сургалтын төвд 30 хүний суудалтай хичээлийн танхимыг тоноглон ажиллуулжээ.

1995 он

Гадаад орнуудаас олон улсын байгууллагын шугамаар 4 зөвлөх мэргэжилтэн урьж татварын албаны ажилтнуудад семинар, зөвлөгөө өгүүлснээс гадна Турк улсад 30 гаруй байцаагч татварын холбогдолтой 7-8 сэдвээр сургалтанд хамрагдсан байна.

1996 он

Татварын байцаагч нарыг олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартаар давтан сургалт явуулах шаардлага гарсан тул төв, орон нутгийн татварын албадад ажиллаж буй чадварлаг байцаагч нарыг сонгон орон нутагт ажиллаж байгаа байцаагч нарт олон улсын нягтлан бодох бүртгэлийн хичээл заах багш нарыг бэлтгэх сургалтыг Улаанбаатар хотноо зохион байгуулсан. Энэхүү сургалтад хамрагдсан багш нар нь үндсэн ажлаа хийхийн зэрэгцээ дүүрэг, орон нутгийн татварын байцаагч нарт олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартаар сургалт явуулсан байна.

1997-1998 он

Татварын байцаагч нарт эрх олгох түвшин тогтоох шалгалтыг 1997 онд зохион байгуулж нийт 1000 орчим байцаагчийг хамруулсан байна. Энэ үеэс сургалтыг анхан, дунд, гүнзгийрүүлсэн гэсэн шаттайгаар зохион байгуулж эхэлсэн бөгөөд одоо ч гэсэн энэ хэлбэрээр сургалт явагдаж байна. Анхан шатны сургалтанд татварын албанд шинээр ажилд орсон, урьд нь сургалтанд хамрагдаагүй, эдийн засгийн мэргэжлийн бус байцаагчдыг, дунд шатанд анхан шатны сургалтанд хамрагдсан байцаагчдыг, гүнзгийрүүлсэн сургалтанд татварын албаны удирдах ажилтан болон ахлах байцаагч нарыг тус тус хамруулан сургаж байна.

Үүний зэрэгцээ хариуцсан ажлын чиглэлээр нь төрөлжсөн сургалт 1999 оноос явуулж эхэлсэн. Тухайлбал, татварын сурталчилгаа, үйлчилгээ хариуцсан байцаагч нарын сургалт семинарыг зохион байгуулсан.

2000-2002 он

Анхан шатны сургалтанд 2001 онд 350 байцаагч хамрагдаж цаашид жил бүр шинээр ажилд орсон 30 байцаагч, ахисан түвшингийн сургалтыг 2002 оноос зохион байгуулж эхний хоёр жилд жил бүр 480 байцаагч, шинээр ажилд орсон 30 байцаагч, дээд шатны сургалтыг 2003 онд зохион байгуулж тус бүр 40 удирдах ажилтан суралцуулахаар төлөвлөж байна.

2001 оноос эхлэн байцаагчдыг мэргэшсэн нягтлан бодогчийн сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулж одоогийн байдлаар 120 хүнийг сургалтанд хамруулж эдгээрээс 63 байцаагч мэргэшсэн нягтлан бодогч болоод байгаа нь нягтлан бодох бүртгэлийн талаар татварын албаны зүгээс тавих шаардлагыг өндөржүүлэхэд чухал алхам болсон. Энэ сургалтанд нийт байцаагчдыг хамруулах шаардлагатай хэдий ч хөрөнгийн эх үүсвэр ихээхэн дутагдалтай байдаг.

Анхан шатны болон ахисан түвшингийн сургалтыг хөдөө орон нутагт зохион байгуулахдаа аймаг бүрт тодорхой графикайн дагуу тухайн аймаг, сумдын байцаагч нарыг аймгийн төвд цугларуулан сургалтын төвийн багш (1-2) томилолтоор очин сургалт явуулж байна. Тухайлбал 2001 онд анхан шатны сургалтыг Баян-Өлгий, Завхан, Говь-Алтай, Сүхбаатар, Булган, Дархан-Уул, Өвөрхангай, Дундговь, Увс аймагт зохион байгуулж нийт 370 гаруй байцаагч хамрагдсан бөгөөд 2002 онд ахисан түвшингийн сургалтыг Өмнөговь, Сэлэнгэ, Булган, Орхон, Архангай, Хэнтий аймгуудад зохион байгуулж одоогоор 180 татварын байцаагч хамрагдаад байна. Орон нутагт хийгдэх сургалтууд нь хөрөнгийн эх үүсвэрээс шалтгаалан тогтмол хийгдэхгүй байгаа бөгөөд 2-3 жилийн дараа хийгдэж байгаа нь байцаагч нарын мэдлэгийг богино хугацаанд дээшлүүлэх шаардлагад нийцэхгүй байна.

5.2 Татварын байцаагч нарт зориулсан шаталсан сургалтын чиг хандлага, үнэлгээ

Татварын байцаагч нарын сургалтын хөтөлбөрийг боловсруулахдаа баримталж буй одоогийн практик нь анхан, ахисан, дээд шат гэж шаталсан хэлбэрээр хийгдэж байгаа болно. Анхан шатны сургалтанд татварын байцаагч нар хамрагдаж татварын онол, практикийн үндсэн зарчмууд, татварын хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, дунд буюу ахисан түвшингийн сургалтанд татварын ногдуулалт, хураалт, татварын хяналт шалгалтын үйл ажиллагаа, дээд шатны сургалтад удирдах ажилтнууд хамрагдаж буй бөгөөд төрийн удирдлага, татварын бодлого сэдвээр тус тус хоёр долоо хоногт 8-10 цагийн нийт 100-120 орчим цагийн хичээл явуулж байгаа болно.

Шаталсан сургалтын бодлогыг концепцын хувьд 2000 онд боловсруулан 2001 оноос үе шаттай хэрэгжүүлж байна. Анхан шатны болон ахисан түвшингийн сургалтыг хөдөө, орон нутагт зохион байгуулахдаа аймаг бүрт тодорхой графикайн дагуу тухайн аймаг, сумдын байцаагч нарын сургалтыг аймгийн төвд 14 хоногийн хугацаатай зохион байгуулж, сургалтын төвийн багш (1-2) томилолтоор очин сургалт явуулж байна.

Сургалтын хэрэгцээ, шаардлага, чанарын үнэлгээний талаарх санал асуулгыг төв, орон нутгийн байцаагч нарын дунд явуулсан дүнгээс харахад сургалтын явцын үнэлгээ сайн, үндсэн ажилд тодорхой нөлөөлөл үзүүлдэг гэсэн байна.

Түүнчлэн орон нутгийн байцаагч нар сургалтыг бүсчилэн явуулах, аймаг, сумдын байцаагч нар бие биенийхээ ажлын туршлагаас суралцах боломжоор хангагдах, сургалтыг төрөлжүүлэн явуулах зэргийг санал болгож, гадаад оронд зохион байгуулагддаг сургалтанд түлхүү оролцох сонирхолтойгоо илэрхийлсэн байна.

Сургалтын төлөвлөгөө дараах байдалтай байна.

5-1 Үндэсний татварын албаны сургалтын төлөвлөгөө (2001-2004)

Зохион байгуулах газар	Төрөл	№	Сургалтын сэдэв	Оролцох хүмүүс	Суралцах хүний тоо			
					2001	2002	2003	2004
ҮТЕГ	Гадаад оронд хийх тусгай сургалт	1	ЭЗХАХБ-ын зардлаар Турк улсын Анкарагийн сургалтын төвд суралцуулах	Удирдах ажилтан, байцаагч нар	27	хуваарийн дагуу	хуваарийн дагуу	хуваарийн дагуу
		2	ЭЗХАХБ-ын зардлаар БНСУ-ын Чонанын сургалтын төвд суралцуулах	Удирдах ажилтан, байцаагч нар	4			
		3	Тайланд улсад программ хангамжийн мэргэжлээр сургах		8			
		4	ОХУ-д аспирантурт сургах		1			
		5	Магистрийн сургалт		3			
		6	Олон улсын татварын асуудлаарх сургалт		2			
		7	Хуулийн мэргэжилтний сургалт	Удирдах ажилтан	2			
	Мэргэжил олгох дотоод сургалт	8	Удирдлагын хөгжлийн академид төрийн удирдлагын чиглэлээр	Удирдах ажилтан	15	2		
		9	Хуулийн дээд мэргэжил эзэмшүүлэх сургалт	Удирдах ажилтан	350			
Сургалт үйлчилгээний төв	Үндсэн сургалт	10	Татварын хууль тогтоомж, НББ-ийн олон улсын стандарт	Байцаагч		30	30	30
		11	Татварын ногдуулалт, хураалт, татварын хяналт шалгалтын үйл ажиллагаа	Байцаагч	40	15* 480**	15* 480**	30
		12	Удирдлагын академитай хамтран төрийн удирдлага, татварын бодлого	Удирдах ажилтан, байцаагч нар	30		40	
	Төрөлжсөн сургалт	13	Олон улсын татвар ба давхар татварын гэрээ	Байцаагч, хэлтэс, тасгийн дарга	35	30	30	30
		14	Онцгой албан татварын хяналт шалгалт	Байцаагч				35
		15	ААНБОАТ-ын баримт бичгийг компьютерээр боловсруулах	Байцаагч, эдийн засагч		30	30	30
		16	Татварын албан дах бүртгэлийн тайлан	Удирдах ажилтан		30		30
		17	Татварын холбогдолтой мэдээллийг компьютер ашиглан боловсруулах	Эдийн засагч, байцаагч		15	15	15
		18	Татварын албаны байцаагчийн ёс зүй	Байцаагч		60	60	60
19	Татварын хэрэг бүртгэл	Байцаагч		30	30	30		

	20	Татварын маргаан таслах	Байцаагч		30	30	30
Тусгайлсан сургалт	21	Мэргэшсэн нябо бэлтгэх	Удирдах ажилтан, байцаагч нар	60	30	30	30
	22	Англи хэлний анхан шатны сургалт	Удирдах ажилтан, байцаагч нар	60	30	30	30
	23	Англи хэлний гүнзгийрүүлсэн сургалт	Удирдах ажилтан, байцаагч нар	60	30	30	30
	24	Англи хэлний ахисан түвшний сургалт	Удирдах ажилтан, байцаагч нар		15	15	20
	25	Компьютерийн сургалт	Удирдах ажилтан, байцаагч нар		40	40	60
	26	Архив бичиг хэргийн материал бэлтгэх	Удирдах ажилтан, байцаагч нар		20	20	20
Төлбөрт сургалт	27	ТИНБ-ийн сургалт	Татвар төлөгч	30	30	30	30
	28	Татварын зөвлөлгөө өгөх ажилтан бэлтгэх сургалт	Татвар төлөгч		40	40	40
	29	НББ, тайлан, татвар ногдуулалт	Татвар төлөгч		30	30	30
	30	Үнэт цаас, нябо бүртгэл, татварын ногдуулалт	Татвар төлөгч		20	20	20
	31	Нябо бүртгэл, валютын үйл ажиллагааны татварын ногдуулалт	Татвар төлөгч		20	20	20
	32	НББ	Татвар төлөгч		30	20	30
	33	Татварын тайлан гаргах, баримтын шалгалт хийх	Татвар төлөгч		30	30	30

* Аймгуудаас хамрагдах хүний тоо

** Дүүргүүдээс хамрагдах хүний тоо

5-2 Үндсэн сургалтын программ

1) Үндсэн сургалт (анхан шат)

Сургалтын сэдэв: Татварын хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт

Зорилго: Татварын албаны нийт байцаагчдад татварын хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын мөн чанарыг ойлгуулах, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чадварыг эзэмшүүлэх, татварын онол, практикийн мэдлэг олгоход оршино.

Сургалтын хугацаа: 18 хоног (108 цаг)

No.	Сэдэв	Заах цагийн тоо
1	Нягтлан бодох бүртгэлийн зохион байгуулалт, нийтлэг зарчмууд	6
2	Бүртгэлийн үе шатууд	6
3	Санхүүгийн баланс	6
4	Мөнгөн хөрөнгийн бүртгэл	2
5	Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ	2
6	Богино хугацаатай хөрөнгө оруулалтын бүртгэл	2
7	Авлагын бүртгэл	4
8	Бараа материал, үнэт зүйлийн бүртгэл	4
9	Урьдчилж төлсөн төлбөр	1
10	Үндсэн хөрөнгийн бүртгэл	4
11	Биет бус хөрөнгийн бүртгэл	2
12	Урт хугацаатай хөрөнгө оруулалтын бүртгэл	2
13	Өр, төлбөрийн бүртгэл	4
14	Эзэмшигчийн өмч ба капиталын бүртгэл	4
15	Орлогын бүртгэл	4
16	Зардал ба газрын бүртгэл	4
17	Онцгой шинжтэй зүйл	1
18	Түрээсийн бүртгэл	2
19	Татварын бүртгэл	2
20	Санхүүгийн тайлан гаргах	1
21	Үлдэгдлийн тэнцэл (СТ-1) гаргах	2
22	Орлогын тайлан (СТ-2) гаргах	2
23	Өмчийн өөрчлөлтийн тайлан гаргах	1
24	Мөнгөн гүйлгээний тайлан	2
25	Санхүүгийн байдлын шинжилгээ	4
26	Баланс хөрвүүлэх ба дүгнэлт гаргах	2
27	Мониторингийн шалгалт	8
28	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын бүртгэл (нийт цаг)	84
29	Татварын онол арга зүй	4
30	Татварын ерөнхий хуулийн агуулга, мөн чанар	2
31	Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн агуулга, мөн чанар	2
32	Хүн амын орлогын албан татварын хуулийн агуулга, мөн чанар	2
33	НӨАТ-ын хуулийн агуулга мөн чанар	2
34	Онцгой албан татварын хуулийн агуулга, мөн чанар	1
35	Үл хөдлөх хөрөнгийн албан татварын хуулийн агуулга, мөн чанар	1
36	Газрын төлбөрийн тухай хуулийн агуулга, мөн чанар	1
37	Улсын тэмдэгтийн хураамжийн хуулийн агуулга, мөн чанар	1
38	Татвар ногдуулалт, төлөлтөнд хяналт тавих, татвар хураах тухай хуулийн агуулга, мөн чанар	2
39	Бусад хууль тогтоомжууд	4

40	Мониторингийн шалгалт	2
41	Татварын хууль тогтоомжийн (нийт цаг)	24
	Нийт цаг	108

Хүснэгт 5-3 Үндсэн сургалт (ахисан шат)

Сургалтын сэдэв: **Татвар хураалтын стратеги**
Зорилго: Сургалтанд хамрагдагсдад татвар хураалтын чиглэлээр дагнасан мэдлэг эзэмшүүлж мэргэшүүлнэ.
Ашиглах материал: УИХ, Засгийн газар, ҮТЕГ-ын бодлого, шийдвэртэй холбоотой болон Азийн хөгжлийн банк, бусад олон улсын курс, семинар, сургалтын материал, техник хэрэгслүүд
Хугацаа: 4 хоног (28 цаг)

No.	Хичээлийн сэдэв	Цаг
1	Монгол улсын татвар хураалтын ажлын өнөөгийн байдал, хуулийн хэрэгжилтийн асуудлууд	2
2	Татвар төлөгчийн бүртгэл ба хяналт	2
3	Бүртгэлийн үндсэн стратеги	2
4	Бүртгэхэд шаардагдах мэдээллийн төрлүүд	2
5	Татвараа өөрөө тодорхойлох систем	1
6	Тайлагнах ба төлөх үүрэг	1
7	Татвараа зөв тодорхойлох	2
8	Жишгээр татвар ногдуулах	2
9	Татвар хураалтын тухай	2
10	Хураалтын үндсэн зарчмууд	1
11	Татварыг үр дүнтэй хураахад тавигдах шаардлага	1
12	Албадан хураах журам	2
13	Шийтгэлийн тухай	1
14	Шийтгэлийн төрлүүд	1
15	Шийтгэлийг хэрэглэх	1
16	Шийтгэлийн уялдаа холбоо	1
17	Олон улсын татварын асуудлууд	1
18	Олон улсын татвараас зайлсхийх аргууд	2
19	Ашгаа гадаад руу шилжүүлэх	1
	Нийт цаг	28

Хүснэгт 5-4 Үндсэн сургалт (ахисан шат)

Сургалтын сэдэв: **Татварын хяналт шалгалт**
Зорилго: Татварын албаны нийт байцаагчдад татварын хяналт шалгалт явуулах шууд ба шууд бус арга зүйг эзэмшүүлэхэд оршино.
Хугацаа: 8 хоног (48 цаг)

No.	Хичээлийн сэдэв	Заах цагийн тоо
1	Татварын хяналт шалгалтын тухай, ТХШ-ын зарчмууд	2
2	ТХШалгалт хийх объектыг сонгох арга, техникүүд	2
3	ТХШалгалтыг шууд аргаар хийх арга зүй, Дэлгэрэнгүй бүртгэлийн дансдыг ТХШ-нд ашиглах нь	2
4	Хураангуй бүртгэлийн дансдыг ТХШ-нд ашиглах нь	2
5	Хөрөнгийн дансдыг ТХШ-нд ашиглах нь	2
6	Зардлын дансдыг ТХШ-нд ашиглах нь	2
7	Мөнгөн хөрөнгийн дансдыг ТХШ-нд ашиглах нь	2
8	Орлого, үр дүнгийн дансдыг ТХШ-нд ашиглах нь	2

9	Хөрөнгийн эх үүсвэрийн дансдыг ТХШ-нд ашиглах нь	2
10	Санхүүгийн тайлан, тэнцлийг ТХШ-нд ашиглах нь	4
11	ТХШ-ыг шууд бус аргаар хийх арга зүй Эдийн засгийн харьцааг ашиглах арга	4
12	Эдийн засгийн модулийн арга	4
13	Орлого, татварыг жишигээр тооцох арга	4
14	Орлогыг амьдралын түвшингээр тооцох арга	4
15	ТХШ явуулахад салбаруудын онцлогуудыг харгалзах нь	4
16	Байцаагчаас акт, хавсралтуудыг үйлдэх, шийдвэрийг тайлбарлах, гомдол барагдуулах	2
17	Мониторингийн шалгалт	4
	Нийт цагийн тоо	48

5.3 Татвар төлөгчдөд зориулсан сургалт, үйлчилгээ

1996 онд анх «Татвар төлөгчийн өдөрлөг»-ийг шинээр санаачлан татвар төлөгчидтэй уулзалт ярилцлага хийх, асуултад нь хариу өгөх, татвар төлөгчдөд зөвлөгөө өгөх зэрэг арга хэмжээ зохион явуулсан.

«Татвар төлөгчийн өдрүүд»-ийг 2000 оноос эхлэн орон даяар 5 сарын хоёрдахь долоо хоногт зохион байгуулж ирсэн. Татвар төлөгчдийн өдөр нь татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээ, сурталчилгааны ажлыг боловсронгуй болгох, татвар төлөх сэтгэлгээг өндөржүүлэхэд чиглэгдсэн чухал арга хэмжээ болсон.

Татварын хуулиудад орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар тайлбарласан сургалтуудыг байгууллагуудын захиалгын үндсэн дээр зохион байгуулж байна. Тухайлбал 2002 оны эхний хагас жилийн байдлаар Хүн амын орлогын албан татвар, Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын хуулийн талаар 30 цагийн сургалт явуулахад нийт 125 хүн хамрагдлаа.

Татвар төлөх үүрэг ухамсрыг зөвхөн өнөөдөр татварын албатай харьцаж байгаа татвар төлөгчдийн хүрээнд бус нийт ард иргэдэд төлөвшүүлэх бодлого боловсруулан «бүх нийтийн татварын боловсрол»-ын системийг бий болгох зорилт тавин ажиллах шаардлагатай.

Энэхүү систем нь цэцэрлэгийн наснаас эхлэн, ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах анги, их, дээд сургууль, коллежийн сургалтын нийгмийн ухааны хичээлийн хөтөлбөрт нас насанд нь тохирсон төр нийгмийн тогтолцооны сургалтын салшгүй нэг хэсэг болон тасралтгүй үргэлжилсэн байх нь зүйтэй. Түүнчлэн насанд хүрэгчдэд зориулсан татварын албан бус боловсролын хөтөлбөр боловсруулах, зайны сургалтыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах зэрэг тулгамдсан зорилтууд тавигдаж байна.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэхэд татвар төлөгчдийн сургалтын материаллаг баазыг бий болгох, сургалтын технологийн шинэчлэлт хийх, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай бөгөөд энэхүү ажлын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байгаа болно.

5.4 Татварын ажилтны сургалтын төслийн санал

5.4.1 Хүсэлт гаргах үндэслэл

(1) *ҮТЕГ дахь боловсон хүчний бэлтгэл*

1998 онд хэрэгжүүлж эхэлсэн «Шилжилтийн эдийн засгийг дэмжих» хөгжлийн судалгаа (Татвар хураалтын тогтоолцоог бэхжүүлэх I, II шат) нь Монгол улсын татвар хураалтын тогтоолцоог бэхжүүлэн төсвийн орлогыг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан.

Энэ судалгааны явцад семинар зохион явуулж технологи дамжуулсан. Гэхдээ бизнесийн үйл ажиллагаа олон төрөл болон хөгжиж байгаа өнөө үед татварын ажилтан үүнд зохицон ажиллахад эдгээр технологи шилжүүлсэн төдийгөөр хангалттай бус бөгөөд цаашдаа өөрсдийн хичээл зүтгэлээр ийнхүү өөрчлөгдөн буй эдийн засгийн нөхцөлд татвар ногдуулан хурааж авах чадвар, арга техникээ ч зохицуулан өөрчлөх шаардлагатай байгаа юм. Үүний тулд сургалтыг системтэйгээр зохион байгуулах хэрэгтэй юм. Өөрөөр хэлбэл, шаардлагатай байгаа сургалтыг үр ашигтай, системтэй, төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнийг хэрэгжүүлж байж л сая ҮТЕГ-ын ажилтнуудын чадвар цаашдын шаардлагад нийцэж чадах болно.

(2) *Татварын нягтлан бодох бүртгэлийг хэвшүүлэх нь*

Мөн татварын ажилтанг ажлынх нь чиглэлээр сургалтанд хамруулж нягтлан бодох бүртгэлийн мэдлэгийг нь дээшлүүлэхийн зэрэгцээ нөгөөтэйгүүр татвар төлөгчийн татварын нягтлан бодох бүртгэлийн мэдлэгийг дээшлүүлэх шаардлагатай юм. Өнөөдөр Монгол улсад томоохон аж ахуйн нэгжүүдэд мэргэшсэн нягтлан бодогч гэх мэт мэргэжилтэй хүмүүс татвар болон нягтлан бодох бүртгэл хариуцан ажиллаж байгаа ба бусад аж ахуйн нэгжүүдийн хувьд их дээд сургуульд нягтлан бодох бүртгэлийн зэрэг авсан хүмүүс ажиллаж байна. Тэдгээр хүмүүс нь зах зээлийн эдийн засаг төлөвшиж хөгжихөд хангалттай чадвар эзэмшсэн гэж хэлэхэд хэцүү юм. Татварын албаны хувьд авч үзэхэд нягтлан бодох бүртгэлийн мэдлэг хангалттай эзэмшсэн гэж хэлэхэд бас хэцүү юм.

Түүнчлэн нягтлан бодох бүртгэлийг хэвшүүлж, бүртгэл хөтлөлтийн түвшинг дээшлүүлбэл татварын тайлагналтын түвшин өсөхөд нөлөөлөхийн дээр татвар төлөгч тал, татвар хураах талын хоорондын ажил хэрэг төвөг саадгүй явагдах болно. Мөн энэ нь татварын тайлагналтын түвшинд сайнаар нөлөөлөөд зогсохгүй бизнесийн дэд бүтэц ч гэж хэлж болох хэлний боловсрол, гадаадаас Монгол улсад орж ирэх хөрөнгө оруулалт, бизнес хөгжихөд ч нөлөөлнө.

5.4.2 Төслийн зорилго

Энэ төслийн урт хугацааны зорилго нь зах зээлийн эдийн засгийн шилжилт, хөгжлийг дэмжих явдал юм. Системчлэгдсэн сургалтын тогтоолцоог бүрдүүлж, хөгжүүлэхтэй холбогдсон технологийг шилжүүлснээр олон төрөл болон хөгжиж буй бизнесийн үйл ажиллагаанд татварын албаны ажилтны зохицож ажиллах чадварыг дээшлүүлж, үүний хамт татвар хураах чадварыг дээшлүүлэхийн хамтаар татварын орлогын өсөлтийг хангах явдал боломжтой болно. Цаашид өөрсдийн хүчин зүтгэлээр сургалтын программыг боловсруулж чаддаг болно.

Шинээр орсон ажилтанд төрийн албан хаагчийн ухамсрыг төлөвшүүлж, татварын ажилтан хүнд шаардлагатай мэдлэг, ур чадвар гэх мэт суурь шинжтэй зүйлсийг эзэмшүүлэх явдлыг зорилго болгосон «Анхан шатны курс», анхан шатны сургалтанд хамрагдсан ажилтнуудын дунд дотоод хяналт шалгалт, ажлын байдал зэргийг харгалзан шалгаруулах шалгалт хэрэгжүүлж, дунд албан тушаалтны ухамсар,

чадварыг төлөвшүүлэх «Дунд шатны курс», улмаар дунд шатны курсэд хамрагдагсдаас тодорхой хугацаанд ажилласны дараа ажиллаж буй төлөв байдлыг харгалзан үзэж, сургалтанд хамруулж, ирээдүйд удирдах ажилтан болгох зорилготойгоор хэрэгжүүлэх «дээд шатны курс»-д хувааж, дээд шатны курсэд татварын онол, удирдлагатай холбоотой судалгаа явуулж, удирдах ажилтны мэдлэг, ур чадвар эзэмших явдлыг зорилго болгон, бодлого тодорхойлдог боловсон хүчин бэлтгэх тал дээр ажиллана. Мөн эдгээр сургалтын түвшинд таарсан сургалтын материал боловсруулж гаргана.

Мөн дээрх зорилгод хүрэхийн тулд Монгол улсын татварын нягтлан бодох бүртгэлийн түвшинг дээшлүүлэх явдал чухал бөгөөд үүний дагуу хийгдэх арга хэмжээ болгож татвар, нягтлан бодох бүртгэлийн түвшин тогтоох системийг нэвтрүүлж, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэхэд зааварчилгаа өгнө.

5.4.3 Төслийн үр дүн

Төсвийн орлогыг нэмэгдүүлснээр санхүүгийн алдагдлыг багасгах боломж бүрдэх бөгөөд Монгол улсын төсвийн орлогын бүрдэлтэд нөлөөлөх юм. Мөн татварын байгууллага болон жирийн иргэдийн татварын бүртгэлийн түвшинг дээшлүүлснээр бизнесийн бааз суурь төлөвшиж, гадны хөрөнгө оруулалтыг идэвхжүүлж, улмаар энэ нь Монгол улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр болох юм.

5.4.4 Төслийн агуулга

(1) *Татварын ажилтны сургалт*

Татварын ажилтанд ёс зүйн төдийгүй татварын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай мэргэжлийн мэдлэг, ур чадварыг эзэмшүүлж, түүнийг хэрэглэх чадвар төлөвшүүлэх шаардлагатай юм. Ийм чадвар бүхий ажилтныг бэлдэх нь их чухал бөгөөд Монгол улсын татварын албанд боловсон хүчин бэлтгэх системтэй, төлөвлөгөөтэй сургалтын систем хангалттай бүрдээгүй байна гэж хэлж болох юм. Энэ нь татвар бүрдэхгүй байгаагийн нэг шалтгаан болж байна.

Монгол улсын татварын ажилтны сургалт нь УТЕГ-ын баталсан сургалтын төлөвлөгөөний дагуу татварын албаны сургалтын төвөөр дамжуулан улс орон даяар хэрэгжиж байгаа билээ. Сургалтын төвд нэг дарга, 4 багш, мөн суртчилгаа, үйлчилгээ хариуцсан 2 байцаагч ажилладаг. Уг алба нь байгуулагдсанаас хойш Монгол улсын татварын бүх ажилтныг хамруулан сургалт явуулж ирсэн ч ажилтнуудын мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтыг цаашид бэхжүүлэх шаардлагатай байна.

1. Боловсон хүчний системийг төлөвшүүлэх

Сургалтын үр ашгийг дээшлүүлэхийн тулд сургалтанд хамрагдагсдын сургалтын амжилтыг тодорхойлж, амжилттай суралцсан хүмүүсийн цалинг тусгайлан өсгөж, улмаар чадварт нь таарсан ажилд ажиллуулах хэрэгтэй юм. Ингэснээр сургалт гэдэг зүйл өөрчлөгдөж ирнэ. Өөрөөр хэлбэл, сургалтын чухлыг ажилтан бүр ухамсарлаж ойлгосноор өрсөлдөөн бий болж, хүн бүр өөрсдийгөө хөгжүүлснээр сургалт улам үр ашигтай болох юм.

Улмаар хойно өгүүлэх 3 шатлалт сургалт дотроос ахисан болон дээд шатны сургалтыг боловсон хүчний асуудалтай холбож хэрэгжүүлэх хэрэгтэй.

2. Орон нутгийн сургалтын системийг хөгжүүлэх

2001 оноос Ховд болон Дорнод аймагт сургалтын төв нээх бэлтгэл ажлыг эхлүүлээд байгаа бөгөөд түүнд шаардлагатай сургалтын материалын зарим хэсгийг бүрдүүлээд байна. Энэ орон нутгийн сургалтын төв нээгдвэл татварын албаны ажилтнуудын сургалтыг орон нутагт явуулах боломжтой болно. Үүнээс гадна орон нутаг дахь сургалтыг хэрэгжүүлэхийн тулд сургалтын гол агуулгын хувьд өнөөг хүртэл явуулж ирсэн сургалтаас гадна видео материал бэлдэж, тухайн орон нутагт нь хангалттай мэдлэг эзэмшүүлэх боломжтой болгох явдал шаардлагатай байна. Мөн алсын сургалтыг ч хэрэгжүүлэх хэрэгтэй.

3. Сургалтын төлөвлөгөө боловсруулах

Монгол улсын татварын ажилтны сургалт нь шинээр орсон ажилтнуудад зориулсан сургалт (анхан шатны сургалт), 3 жил хүртэл ажилласан ажилтнуудад явуулах сургалт (ахисан шатны сургалт), 3-аас дээш жил ажилласан ажилтнуудад хийх сургалт (дээд шатны сургалт)-аас бүрдэнэ. Гэхдээ энэхүү гурван шатлалт сургалтаар сургалтанд хамрагдагсад тус бүрийн чадварын түвшинг тогтоох нөхцөл тодорхойгүй байдаг. Иймээс сургалтын агуулга болон сургалтын төлөвлөгөө нь ихэнхдээ ижил байдаг бөгөөд сургалтанд хамрагдагсад өгөх мэдээллийн хэмжээгээрээ л бага зэрэг ялгаатай байдаг байна.

Татварын ажилтан нь төрийн албан хаагчийн хуулийн дагуу Монгол улсын захиргааны байгууллагын ажилтан мөн тул зарчмын хувьд нэг ажилтан тэтгэвэрт гартлаа он удаан жил ажиллах нөхцөл бүрдсэн байдаг. Иймээс татварын ажилтны чадвар нь сургалт, ажиллах туршлага хуримтлагдахын хэрээр улам нэмэгддэг тийм сургалтын арга барилыг нэвтрүүлэх боломж байгаа юм. Монгол улсын хувьд одоогийн хуулиар төрийн албан хаагчийг авч ажиллуулах нөхцөл бүрдсэн байдаг бөгөөд татварын ажилтнуудын дотор их дээд сургууль төгссөн хүмүүс дийлэнх хэсгийг эзэлдэг. Их дээд сургууль төгсөж, татварын албанд орсон хүмүүст зориулсан сургалтын хувьд түүний ажилласан жилийг нь харгалзан шаталсан сургалтыг хэрэгжүүлэх нь үр дүнтэй юм. Иймээс дээрх анхан, дунд, дээд шатаар хэрэгжүүлэх сургалт нь үр ашигтай гэж хэлж болно. Гэхдээ дээр дурдсанчлан сургалт тус бүрийн агуулга, сургалтын хөтөлбөр нь бараг адил, сургалтанд хамрагдагсад өгөх мэдээллийн хэмжээгээрээ л бага зэрэг ялгаатай байдаг. Иймээс сургалт тус бүрийн сургалтын материалыг боловсруулж, гурван шатлалт сургалтыг агуулгын хувьд ялгаатай болгож, сургалтыг зохих байдлаар хэрэгжүүлэх хэрэгтэй юм.

Үүнээс гадна гадаад хамтын ажиллагаа, гадаад улстай харилцах татварын хамтын ажиллагаа өргөжин хөгжиж байгаа өнөө үед татварын албаны ажилтны хэлний боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай юм. Нөгөөтэйгүүр, гадаад оронд явагдах сургалт, семинарт олон тооны ажилтнуудыг хамруулах нь энэхүү хэлний боловсролоос шалтгаална гэдгийг бодолцон, хэлний боловсролыг чанартай явуулахад анхаарч ажиллах хэрэгтэй. Энэ нь эдийн засаг, нийгмийн глобальчлалын үүднээс авч үзлээ ч зайлшгүй шаардагдаж буй зүйл юм.

4. Текст болон видео хэлбэрийн сургалтын материалыг гаргах

Мэргэжлийн чадварыг дээшлүүлэх мэдлэг олж эзэмших явдлыг боломжтой болгохын тулд мэргэжлийн гол гол мэдлэгийн тал дээр сурах бичиг болон видео материал боловсруулахад нийт орон даяар анхаарч ажиллах

5. Сургалтын үр дүнг тодорхойлох

Нийт сургалтанд хамсрагдагсад энэ түвшинг хангаж буй эсэхийг үнэлэх журмыг

нэвтрүүлэх шаардлагатай.

6. Японд Монголын татварын ажилтнуудыг сургах тусгай сургалт

Сургалт хариуцсан ажилтныг бэлтгэхийн тулд сургалт хариуцан ажиллах чадвартай хүмүүсийг голчлон Японд шаардлагатай сургалтанд явуулах

(2) *Татвар болон нягтлан бодох бүртгэлийн түвшинг дээшлүүлэх, татварын бүртгэлийн чадварыг тогтоох системийг төлөвшүүлэх нь*

Татвар болон нягтлан бодох бүртгэлийн түвшинг дээшлүүлэх шаардлага бий. Үүний тулд татварын бүртгэлийн түвшин тогтоох шалгалтын системийг нэвтрүүлэх нь үр дүнтэй гэж бодож байна. Иймээс дараах гол гол асуудлаар татвар болон нягтлан бодох бүртгэлийн олон улсын түвшинг дээшлүүлэх, татварын бүртгэлийн түвшин тогтоох тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай.

- Татварын бүртгэлийн боловсрол ба түвшингийн өнөөгийн байдал, зорилтын анализ
- Мэргэжлийн чадвар тогтоох системийг нэвтрүүлэх боломжийг судлах
- Системийг хэрэгжүүлэх тогтолцооны төсөл ба хэрэгжүүлэх чиглэлийг боловсруулах
- Хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргах

5.4.5 Судалгаанаас гарах бүтээл

Татвар болон нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой сургалтын материал гаргах

Татварын ажилтны сургалтын төлөвлөгөө боловсруулах

Видео материал гаргах

Татварын бүртгэлийн түвшин тогтоох шалгалтын асуудал боловсруулах

Татварын бүртгэлийн чадварыг тогтоох системийг нэвтрүүлэх

Хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагааны загварыг боловсруулах